



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөв өсөж байгаатай зэрэгцэн төлөвлөлтийн шаардлага хангаагүй, урсгал зардлын шинж чанартай төсөл арга хэмжээ нэмэгдсэн байна.

АУДИТЫН КОД: ОРА-2025/06-13-ШТА-ГА



Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва
Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvar@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Буян-Ундрах
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn
Ахлах аудитор: Т.Болормаа
Утас: 70355805 Цахим хаяг: bolormaat@audit.gov.mn
Аудитор: Ц.Одгэрэл
Утас: 70357955 Цахим хаяг: odgerelts@audit.gov.mn
Аудитор: А.Лхагвагэрэл
Утас: 70355805 Цахим хаяг: lkhagvagerela@audit.gov.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт	4
Хүснэгтийн товъёг	4
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүйн талаарх мэдээлэл	5
Үндсэн мэдээлэл	7
БҮЛЭГ 1. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг эдийн засгийн өгөөж, ач холбогдлын тооцоолгүй төлөвлөж, баталсаар байна.	9
БҮЛЭГ 2. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 12 ТАХ-г хэрэгжүүлж, үнэлгээний хороо чанарын баталгаа, алданги тооцох хувь хэмжээг харилцан адилгүй шаардсан байна.	16
БҮЛЭГ 3. Хэрэгжиж дууссан ТАХ-г гүйцэтгэл, хүлээн авсан баримтад үндэслэн санхүүжилтийг олгож, зураг төсөвгүй, техникийн тодорхойлолтгүй ТАХ баталж байгаа нь хугацаандаа хэрэгжүүлэх боломжийг алдагдуулжээ.	24
Дүгнэлт:	37
Зөвлөмж:	38
“Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд, үр дүн” гүйцэтгэлийн аудитын зөрчлийн нэгтгэл	39
Байгууллагын санал:	42



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2025 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/10

Эрдэнэт

**Аудитын тайлан баталгаажуулах
тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан "Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх"-ийн 1.1, 1.4 дэх хэсэг, "Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам"-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Улс, орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

3. Аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгаж, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулж, аймгийн хэмжээнд нэгтгэн, үр дүнгийн талаар 2025 оны 12 дугаар сарын 10-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг аймгийн Засаг дарга (Б.Зоригтбаяр), Баян-өндөр сумын Засаг дарга (Б.Мөнхбаяр), Жаргалант сумын Засаг дарга (Л.Учрал), Худалдан авах ажиллагааны газрын дарга (Д.Оюунбаяр) нарт зөвшөөрсүгэй.

4. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, Нийслэл дэх Төрийн аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, Баян-өндөр сумын Засаг дарга, Жаргалант сумын Засаг дарга, Худалдан авах ажиллагааны газарт тус тус хүргүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын менежер (Б.Буян-Ундрах), Ахлах аудитор (Т.Болормаа), аудитор (Ц.Одгэрэл), (А.Лхагвагэрэл), (Л.Болормаа) нарт даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ПҮРЭВЛХАГВА

D:\my doc\bichig hereg\ tushaal\2025.doc

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУ	Монгол улс
УИХ	Улсын их хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХТГ	Хот тохижуулах газар
ХЭЗХ	Хууль, эрх зүйн хэлтэс
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
БОГ	Байгаль орчны газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
АЗС	Авто замын сан
ЭТС	Эрдэнэт сан
БХС	Байгаль хамгаалах сан
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар

Хүснэгтийн товъёг

Хүснэгт 1	2024 оны төсвөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын ТАХ
Хүснэгт 2	2024 оны тодотгосон төсвөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын ТАХ
Хүснэгт 3	Баян-Өндөр сумын ИТХ-р баталсан хөрөнгө оруулалтын ТАХ
Хүснэгт 4	Жаргалант сумын ИТХ-р баталсан хөрөнгө оруулалтын ТАХ
Хүснэгт 5	Урт хугацааны бодлогын баримт бичигтэй нийцэхгүй төлөвлөсөн ТАХ
Хүснэгт 6	Ач холбогдолгүй ТАХ-ний жагсаалт
Хүснэгт 7	Тоног төхөөрөмжийн жагсаалт
Хүснэгт 8	Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн ТАХ-ний жагсаалт
Хүснэгт 9	Аймгийн хэмжээнд өвс тэжээлийн нөөц 2024.12.31-ний байдлаар
Хүснэгт 10	Худалдан авах ажиллагааны 2024 оны төлөвлөгөө
Хүснэгт 11	Худалдан авах ажиллагааны үр дүн
Хүснэгт 12	Худалдан авах ажиллагааны гомдол шийдвэрлэсэн байдал
Хүснэгт 13	Зохион байгуулсан худалдан авах ажиллагаа
Хүснэгт 14	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй ТАХ
Хүснэгт 15	Батлагдсан нэршилтэй нийцэхгүй ТАХ
Хүснэгт 16	Санхүүжилт олгосон мэдээлэл
Хүснэгт 17	Санхүүжилт олгосон байдлыг задлан харуулбал
Хүснэгт 18	Хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан баталгаа
Хүснэгт 19	Төсөл, хөтөлбөрийн зарцуулалтын задаргаа
Хүснэгт 20	Төсөл, хөтөлбөрийн зарцуулалтын задаргаа
Хүснэгт 21	ТАХ-ний бүртгэлийг эх үүсвэр бүрээр задалбал

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүйн талаарх мэдээлэл**Аудит хийх
үндэслэл, бүрэн
эрх**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2024 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны А/108 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөөний ” дагуу аудитыг хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдсэн. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх,
- Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх,
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан эсэх.

**Аудитын хамарсан
хүрээ**

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга, аймгийн Засаг даргын тамгын газар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Худалдан авах ажиллагааны газар, Орон нутгийн өмчийн газар, Хот байгуулалт барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ зэрэг холбогдох байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг хамруулан гүйцэтгэлээ.

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын

Аудитын арга зүй

стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, аудитыг чиглүүлж гаргасан бусад заавар, аргачлал, гарын авлагыг мөрдөж ажиллав.

Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитад дараах шалгуур үзүүлэлтүүдийг ашиглалаа. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт,
- Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Барилгын тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”,
- Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр,
- Засгийн газрын 2021 оны 160 дугаар, 2023 оны 278 дугаар тогтоолоор тус тус баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”,

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор П.Пүрэвлхагва удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Б.Буян-Ундрах хэрэгжүүлэн, ахлах аудитор Т.Болормаа, аудитор Ц.Одгэрэл, А.Лхагвагэрэл, Л.Болормаа нар 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэв.

Аудитын явцад учирсан хүндрэл, бэрхшээлүүд

Аудитын явцад хүндрэл, бэрхшээл үүсээгүй болно.

Үндсэн мэдээлэл

Орхон аймгийн ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 17/04 дүгээр тогтоолоор хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг 104,292.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 68,289.2 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 377 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталсан байна.

2024 оны аймгийн төсвөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын ТАХ

Хүснэгт 1

/сая төгрөгөөр/

Хөрөнгө оруулалтын төрөл		ТАХ-ний төрөл	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
ОНХО	Шилжих хөрөнгө оруулалт	Барилга байгууламж	24	49,452.4	16,865.3
		Их засвар	5	326.3	194.3
		Зөвлөх үйлчилгээ	7	819.3	728.4
		Тоног төхөөрөмж	3	2,055.0	2,055.0
	Шинээр эхлэх хөрөнгө оруулалт	Барилга байгууламж	98	23,512.5	23,367.5
		Зөвлөх үйлчилгээ	1	1,000.0	1,000.0
		Тоног төхөөрөмж	36	6,510.6	6,510.6
Авто замын сан	Шинээр эхлэх хөрөнгө оруулалт	Төсөл, хөтөлбөр	185	11,616.3	11,616.3
		Барилга байгууламж	2	672.0	672.0
		Тоног төхөөрөмж	1	46.5	46.5
Эрдэнэт сан	Шинээр эхлэх хөрөнгө оруулалт	Төсөл хөтөлбөр	3	1,243.5	1,243.5
		Шилжих хөрөнгө оруулалт	4	6,499.9	3,451.7
		Шинэ хөрөнгө оруулалт	8	538.1	538.1
Нийт дүн			377	104,292.4	68,289.2

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 18/05 дугаар тогтоолоор төсвийг тодотгож 125,682.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 80,386.7 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 425 ТАХ-г хэрэгжүүлэхээр тодотгожээ.

2024 оны тодотгосон төсвөөр хэрэгжих хөрөнгө оруулалтын ТАХ

Хүснэгт 2

/сая төгрөгөөр/

Хөрөнгө оруулалтын төрөл		ТАХ-ний төрөл	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
ОНХО	Шилжих хөрөнгө оруулалт	Барилга байгууламж	32	54,697.6	17,292.5
		Их засвар	5	326.3	194.3
		Зөвлөх үйлчилгээ	7	819.3	728.4
		Тоног төхөөрөмж	3	2,055.0	2,055.0
	Шинээр эхлэх хөрөнгө оруулалт	Барилга байгууламж	114	34,922.8	30,481.4
		Зөвлөх үйлчилгээ	1	3,000.0	3,000.0
		Тоног төхөөрөмж	53	7,687.8	7,687.8
Авто замын сан	Шинээр эхлэх хөрөнгө оруулалт	Төсөл, хөтөлбөр	190	12,986.1	12,986.1
		Барилга байгууламж	4	859.8	681.4
		Тоног төхөөрөмж	1	46.5	46.5
Эрдэнэт сан	Шинээр эхлэх хөрөнгө оруулалт	Төсөл хөтөлбөр	3	1,243.5	1,243.5
		Шилжих хөрөнгө оруулалт	4	6,499.9	3,451.7
		Шинэ хөрөнгө оруулалт	6	38.1	538.1
Нийт дүн			425	125,682.7	80,386.7

Баян-Өндөр сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 17/04 дүгээр тогтоолоор хөрөнгө оруулалтын 7,143.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 5,858.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 34 ТАХ-г баталсан байна.

Баян-Өндөр сумын ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны 21/02 дугаар тогтоолоор төсөвт тодотгол оруулж, 8,342.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 7,312.6 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 68 ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Баян-Өндөр сумын ИТХ-р баталсан хөрөнгө оруулалтын ТАХ

Хүснэгт 3

/сая төгрөгөөр/

Хөрөнгө оруулалтын төрөл	ТАХ-ний төрөл	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	2024 онд санхүүжих дүн
Шилжих хөрөнгө оруулалт	Барилга байгууламж	1	1,095.1	76.1
	Төсөл, хөтөлбөр	1	282.9	272.5
Шинээр эхлэх хөрөнгө оруулалт	Барилга байгууламж	3	590.0	590.0
	Тоног төхөөрөмж	7	594.0	594.0
	Төсөл, хөтөлбөр	16	1,672.8	1,672.8
Байгаль хамгаалах сан	Барилга байгууламж	13	2,879.6	2,879.6
	Тоног төхөөрөмж	3	98.0	98.0
	Зөвлөх үйлчилгээ	6	149.7	149.7
	Төсөл, хөтөлбөр	18	979.9	979.9
Нийт дүн		68.0	8,342.0	7,312.6

Жаргалант сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор хөрөнгө оруулалтыг 5,462.8 сая, төсөл хөтөлбөр 904.1 сая, зөвлөх үйлчилгээ 200.0 сая, нийт 6,566.9 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 40 ТАХ-г баталсан байна.

Жаргалант сумын ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор 9,653.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 6,534.6 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 39 ТАХ-г сумын хөрөнгөөр санхүүжүүлэхээр тодотгол хийжээ.

Жаргалант сумын ИТХ-р баталсан хөрөнгө оруулалтын ТАХ

Хүснэгт 4

/сая төгрөгөөр/

Хөрөнгө оруулалтын төрөл	ТАХ-ний төрөл	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	2024 онд санхүүжих дүн
Шилжих хөрөнгө оруулалт	Барилга байгууламж	1	4,349.9	1,231.1
Шинээр эхлэх хөрөнгө оруулалт	Хөрөнгө оруулалт	13	4,315.4	4,315.4
	Тоног төхөөрөмж	6	147.6	147.6
	Төсөл, хөтөлбөр	18	663.6	663.6
	Зөвлөх үйлчилгээ	1	176.9	176.9
Нийт дүн		39	9,653.4	6,534.6

БҮЛЭГ 1. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг эдийн засгийн өгөөж, ач холбогдлын тооцоолгүй төлөвлөж, баталсаар байна.

1.1 Хөрөнгө оруулалтын ТАХ нь “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой 92.8 хувь нийцэж байгаа ч урсгал зардлын шинж чанартай төсөл хөтөлбөрийн зардал өмнөх оноос өссөн байна.


Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор “Алсын Хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг баталсан.

Тухайн бодлогын баримт бичиг нь Үндэсний нэгдмэл үнэт зүйл, Хүний хөгжил, Амьдралын чанар ба дундаж давхарга, Эдийн засаг, Сайн засаглал, Ногоон хөгжил, Амар тайван аюулгүй нийгэм, Бүс, Орон нутгийн хөгжил, Улаанбаатар ба дагуул хот гэсэн 9 зорилго, 45 зорилтод хуваагдаж байна.

Орхон аймаг 2024 онд нийт 121,029.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 283 ТАХ-г 6 эх үүсвэрээс санхүүжүүлэхээр төлөвлөн баталсан байна.

ОНХО-аар 2024 онд төлөвлөсөн ТАХ-үүд нь “Алсын Хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилготой нийцсэн байдлыг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл 1




Нийт төлөвлөсөн ТАХ-ний 1.1 хувь нь Үндэсний нэгдмэл үнэт зүйл, 26.5 хувь нь “Хүний хөгжил” зорилгыг, 4.9 хувь нь “Амьдралын чанар ба дундаж давхарга” зорилгыг, 16.6 хувь нь “Эдийн засаг” зорилгыг, 25.1 хувь нь “Засаглал” зорилгыг, 7.8 хувь нь “Ногоон хөгжил” зорилгыг, 11.7 хувь нь “Амар тайван аюулгүй нийгэм” зорилгыг хангахад чиглэсэн байна. Үлдсэн 6.4 хувь буюу 18 ТАХ нь “Алсын Хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 9 зорилгын аль нэгт хамаарахгүй ТАХ-г төлөвлөсөн байна.

Нийт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 283 ТАХ-ээс “Алсын Хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн “Хүний хөгжил” зорилгыг хангахад чиглэсэн 75 ТАХ, “Засаглал” зорилгыг хангахад чиглэсэн 71 ТАХ, “Эдийн засаг” зорилгыг хангахад чиглэсэн 47 ТАХ-г төлөвлөсөн байна.

Орхон аймгийн ИТХ-ын 2020 оны 02/01 дүгээр тогтоолоор “Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг 8 үнэт зүйлтэй 33 зорилттой хэрэгжүүлэхээр баталсан байна.

Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлтэй 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 283 ТАХ хэрхэн нийцсэн талаар дүрслэлээр харуулбал:

Дүрслэл 2



Нийт төлөвлөсөн ТАХ-ний 1.1 хувь нь Үндэсний нэгдмэл үнэт зүйл, 17.0 хувь нь “Эрүүл, бүтээлч, хөгжих тэмүүлэлтэй – Эрдэнэт хүн” зорилгыг, 4.9 хувь нь “Амьдралын чанар ба дундаж давхарга” зорилгыг, 16.6 хувь нь “Эдийн засаг” зорилгыг, 19.1 хувь нь “Тогтвортой засаглал – Эрдэнэт хүч” зорилгыг, 7.8 хувь нь “Ногоон - Эрдэнэт хот ” зорилгыг, 26.1 хувь нь “Аюулгүй амар тайван – Эрдэнэт хот”, 1.1 хувь нь “Тогтвортой хөгжил – Эрдэнэт хот” зорилгыг хангахад чиглэсэн байна. Үлдсэн 6.4 хувь буюу 18 ТАХ нь Орхон аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн аль нэг зорилгод хамаарахгүй ТАХ-г төлөвлөсөн байна.

Нийт хэрэгжсэн 283 ТАХ-ээс “Алсын Хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн “Хүний хөгжил” зорилгыг хангахад чиглэсэн 75 ТАХ, “Засаглал” зорилгыг хангахад чиглэсэн 71 ТАХ, “Эдийн засаг” зорилгыг хангахад чиглэсэн 47 ТАХ-г төлөвлөсөн байна.

Урт хугацааны бодлогын баримт бичигтэй нийцэхгүй төлөвлөсөн ТАХ-д

Хүснэгт 5

/сая төгрөгөөр/

№	Аймаг, сумын нэр	ТАХ-ний нэр	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Төсөвт өртөг
1	Орхон аймаг	Хөв цөөрмийн ажлыг дуусгах /Эрдэнэ баг. Бүрэн бүст овооны хажууд/	2023	2024	284.77
2	Орхон аймаг	Зэвсэгт хүчний 186 дугаар ангийг түшиглэн буудлагын талбай байгуулах	2023	2024	60.00
3	Орхон аймаг	Найрамдал өндөрлөгийн шат болон тойрсон хэсгийн бэхэлгээний хананд засвар хийх	2023	2024	50.00
4	Орхон аймаг	Эрдэнэт хотын цахим түүх бүтээх	2023	2024	150.00

5	Орхон аймаг	Эрчим хүчний хэмнэлттэй Хайбрид амины орон сууц барих	2024	2024	54.94
6	Орхон аймаг	Дэнж багийн Элит I,II байрны гадна фасад, заадсыг засварлах	2024	2024	226.48
7	Орхон аймаг	Их залуугийн өвөрт шинээр баригдах "Далай их буян" ХХК-ийн буяны цогцолборын цахилгаан хангамжийн 6кВ-ын агаарын шугам, 6/0,4кВ-ын КТПН маягийн 160кВА чадалтай дэд станцын барилга угсралт хийх	2024	2024	258.29
8	Орхон аймаг	Зэст баг. Шуудангийн үйлчилгээний газрын хэсэгчилсэн засвар хийх	2024	2024	97.01
9	Орхон аймаг	Эрдэнэ баг. Эрчим хүчний хэмнэлттэй 37-н айлын Хайбрид гарден хотхоны гадна тохижилт хийх	2024	2025	1,986.77
10	Орхон аймаг	Эрдэнэт хотын түүх, дурсгалын ном гаргах	2024	2024	20.00
11	Орхон аймаг	Улаан загалмайн хороонд микро автобус худалдан авах	2024	2024	45.00
12	Орхон аймаг	Цэцэрлэгт хүрээлэнд техник хэрэгсэл худалдан авах	2024	2024	19.85
13	Орхон аймаг	Хорих ангийн дээврийн засвар хийхэд шаардлагатай материал худалдан авах	2024	2024	111.84
14	Орхон аймаг, Баян-Өндөр	Сонгуулийн самбар худалдан авах	2024	2024	30.00
15	Орхон аймаг, Баян-Өндөр	Бренд бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд сав баглаа боодол худалдан авах	2024	2024	70.00
16	Орхон аймаг, Баян-Өндөр	Баян-Өндөр сумын хөрсний доройтлыг бууруулах ажлын хүрээнд тарьц, суулгацын нөөц бүрдүүлэх зорилгоор 6*20 харьцаатай 6 иж бүрэн хүлэмжийг ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа нөхөрлөлүүдэд олгож үйл ажиллагааг дэмжих	2024	2024	60.00
17	Орхон аймаг, Жаргалант	Сайжруулсан шороон замын урсгал засвар	2024	2024	20.00
18	Орхон аймаг, Жаргалант	Улаантолгой, жаргалант багийн хуучин тоглоомын талбайн урсгал засвар	2024	2024	20.00
Нийт төсөвт өртөг					<u>3,565.0</u>

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 12,986.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 190 ТАХ, Эрдэнэт сангаас 38.1 сая төгрөгийн 2 ТАХ, Авто замын сангаас 1,243.5 сая төгрөгийн 3 ТАХ, Байгаль хамгаалах сангаас 979.9 сая төгрөгийн 18 ТАХ, Баян-өндөр сумын 1,945.3 сая төгрөгийн 17 ТАХ, Жаргалант сумын 1,929.5 сая төгрөгийн 13 ТАХ-г хэрэгжүүлэхээр баталжээ.


Тайлант онд нийт 19,122.4 сая төгрөгийн 243 хөрөнгө оруулалтын шинж чанаргүй төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээр аймаг сумдын ИТХ баталсан нь төсвийн тухай хуулийн 4.1.24¹-т заасныг зөрчсөн байна.

Төсөл хөтөлбөрийн төлөвлөлт

Дүрслэл 3

/сая төгрөгөөр/

¹ "төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;



Тайлант онд батлагдсан төсөл хөтөлбөрийн зардал нь өмнөх онуудтай харьцуулахад тоо хэмжээ, санхүүжүүлэх дүн өссөн байна.

Тэргүүлэх ач холбогдолтой, зайлшгүй хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагатай, тооцоо судалгаатай бүтээн байгуулалтын ТАХ-г төлөвлөж, баталж байх талаар жил бүр Төрийн аудитын байгууллагаас зөвлөмж, албан шаардлага хүргүүлсэн боловч хэрэгжилт хангагдахгүй байсаар байна.

1.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг эрэмбэлэн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцоололгүй төлөвлөсөөр байна.

Аймгийн хөрөнгө оруулалтын жагсаалтад 7,271.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 3,409.2 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 11 ТАХ-г ач холбогдлоор эрэмбэлж, эдийн засгийн үр ашиг тодорхойгүй хөрөнгө оруулалтыг төлөвлөжээ.

Ач холбогдолгүй ТАХ-ний жагсаалт

Хүснэгт 6

/сая төгрөгөөр/

№	ТАХ-ний нэр	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
1.1.2	БОАЖГ-ын контор, орон сууцны инженерийн шугам сүлжээний ажил	212.60	212.6
1.1.10	Эрдэнэт Ус ДТС ОНӨХК-ийн Захиргааны байр барих	3,353.49	605.1
1.1.16	Хөв цөөрмийн ажлыг дуусгах /Эрдэнэ баг. Бүрэнбүстийн овооны хажууд/	284.77	170.9
1.1.23	Зэвсэгт хүчний 186 дугаар ангийг түшиглэн буудлагын талбай байгуулах	60.00	60.0
1.4.2	Эрдэнэт хотын цахим түүх бүтээх	150.00	150.0
2.1.36	Эрчим хүчний хэмнэлттэй Хайбрид амины орон сууц барих	54.94	54.9
2.1.37	Нутгийн удирдлагын ордны 3 дугаар давхрын өрөөг хүндэтгэлийн танхим болгон засварлаж тохижуулах	186.90	186.9
2.1.95	Яргуйт, Баян-Овоот багийн байр болон 28-р цэцэрлэгийг халаалтын нүүрстөрөгч багатай эх үүсвэртэй холбох / орон нутгийн оролцоо/	750.00	750.0
2.1.104	Зэст баг. Шуудангийн үйлчилгээний газрын хэсэгчилсэн засвар хийх	97.01	97.0
2.1.107	Эрдэнэ баг. Эрчим хүчний хэмнэлттэй 37-н айлын Хайбрид гарден хотхоны гадна тохижилт хийх	1,986.77	986.8
2.1.110	Зэст баг. Орон сууцны 1-р хорооллын 21-р байрны орц засварлах	135.00	135.0

Нийт дүн	7,271.48	3,409.22
----------	----------	----------

Аймгийн хөрөнгө оруулалтын ТАХ-нд тоног төхөөрөмжийн жагсаалтад батлагдсан 446.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хэрэгцээ шаардлагагүй 8 ТАХ-г төлөвлөж, баталсан байна.

Тоног төхөөрөмжийн жагсаалт

Хүснэгт 7

/сая төгрөгөөр/

№	ТАХ-ний нэр	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
2.3.8	Хүндэт харуулын үйл ажиллагаанд шаардлагатай хивс худалдан авах	21.7	21.7
2.3.23	Биеийн тамир спортын газарт тоног төхөөрөмж худалдан авах	120.0	120.0
2.3.24	Чөлөөт бөхийн холбоонд дэвжээ худалдан авах	40.0	40.0
2.3.25	Эрдэнэт хотын түүх, дурсгалын ном гаргах	20.0	20.0
2.3.32	Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж худалдан авах	100.0	100.0
2.3.33	Уурхайчин баг. Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж худалдан авах	80.0	80.0
2.3.51	Цэцэрлэгт хүрээлэнд техник хэрэгсэл худалдан авах	19.85	19.85
2.3.35	Улаан загалмайн хороонд микро автобус худалдан авах	45.0	45.0
	Нийт дүн	446.5	446.5

Хөрөнгө оруулалтын 283 ТАХ-г иргэд, ИТХ-ын төлөөлөгч нараас санал авсан боловч ач холбогдлоор нь хэрхэн эрэмбэлсэн, төлөвлөлтийн шаардлага хангасан ТАХ-г оруулсан талаар хангалттай зохистой нотлох баримт байхгүй байна.

1.3 Эдийн засгийн үр өгөөж бага, хөрөнгө оруулалтын шинж чанаргүй ТАХ-г төлөвлөсөөр байна.

Аймгийн хэмжээнд хөрөнгө оруулалтын 283 ТАХ-ээс 207 ТАХ нь барилга, байгууламж, их засвар, зам засвар, гэрэлтүүлэг камерын шинэчлэлтийн ТАХ төлөвлөсөн байна.

Эрдэнэт үйлдвэрлэв барилга барих 3,582.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилга байгууламж нь иж бүрэн батлагдсан зураг төсөвгүй төлөвлөгдөж, "Эрдэнэтэд үйлдвэрлэв" төвийн барилгын зураг төсөл боловсруулах ТАХ нь шилжих үлдэгдэлд 37.5 сая төгрөг батлагдсан нь Барилгын тухай хуулийн 4.1.30², Төсвийн тухай хуулийн 29.4³-т заасныг зөрчсөн байна.

² "зураг төсөл" гэж барилга байгууламжийг төлөвлөх, барилгын ажил гүйцэтгэхэд шаардагдах загвар зураг, эх загвар зураг /эскиз/, техник, эдийн засгийн үндэслэл, техникийн болон ажлын зураг, барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын төсөл, инженер хайгуулын судалгаа, инженер геологи, геодезийн зураглал, инженерийн тооцоо, өртгийн төсөв зэрэг баримт бичгийн иж бүрдлийг;

³ санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах;

Уртын гол багт баригдаж байгаа 260 айлын 5 блок орон сууцны цогцолборын ажил нь 2021 оноос хойш он дамнан хэрэгжиж, техник эдийн засгийн үндэслэлгүй төлөвлөгдөж 2024 оны байдлаар 82%-ийн гүйцэтгэлтэй байна.

Уурхайчин багт Тамир зочид буудлын урд УДХТөв байгуулах ТАХ нь 2023 оноос хойш хэрэгжихдээ техник эдийн засгийн үндэслэлгүй төлөвлөгдөж, 2024 оны байдлаар 80%-тай байна.

Хөрөнгө оруулалтын ТАХ нь аймагт 4 эх үүсвэр, Баян-Өндөр суманд 2 эх үүсвэр, Жаргалант суманд 1 эх үүсвэрээс нийт 283 ТАХ-нд 121,029.9 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсний 7,205.1 сая төгрөг нь болзошгүй аваарын зардал байна.

Болзошгүй аваарын зардлын гүйцэтгэлээр аймаг 117 ТАХ-нд 5,456.3 сая төгрөг, Баян-Өндөр сум 14 ТАХ-нд 267.8 сая төгрөг, Жаргалант сум 36 ТАХ-нд 1,469.3 сая төгрөг нийт 167 ТАХ-нд 7,193.1 сая төгрөгийг зарцуулжээ.

Аймгийн хөрөнгө оруулалтын төсөвт өртөг жил бүр өсөж байгаа боловч эдийн засгийн үр өгөөж жилээс жилд буурч байгаа нь олон жижиг ТАХ-г олон эх үүсвэрээс баталж, ТАХ-г давхардуулах, төлөвлөлтийн оновчтой бус байдлаас хэрэгжилт удаашрах, ач холбогдолгүй хөрөнгө оруулалт нэмэгдэх, төсөл хөтөлбөрийн үр ашиггүй зардлууд нэмэгдэх зэрэг эрсдэлийг дагуулж байна.

1.4 Тайлант онд өвс тэжээлийн нөөц, давс бодисын нөөцийг ихээр бэлтгэж бараа материалын үлдэгдлийг өмнөх оноос 2 дахин илүү нөөцөлсөн нь Төрийн хэмнэлтийн хуультай нийцэхгүй байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын ТАХ-ны жагсаалтад дараах 5 ТАХ-г баталж хэрэгжүүлсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3.2⁴-т заасныг зөрчсөн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн ТАХ-ний жагсаалт

Хүснэгт 8

/сая төгрөгөөр/

№	Дугаар	Төсөл арга хэмжээний нэр	2024 оны төсөвт өртөг	Гүйцэтгэлээр санхүүжилт
1	1.1.2	БОАЖГ-ын контор, орон сууцны инженерийн шугам сүлжээний ажил	212.6	91.6
2	2.3.31	Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж худалдан авах	100.0	0.0
3	2.3.32	Уурхайчин баг. Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж худалдан авах	80.0	78.9
4	2.1.36	Эрчим хүчний хэмнэлттэй Хайбрид амины орон сууц барих	54.9	54.9
5	2.1.107	Эрдэнэ баг. Эрчим хүчний хэмнэлттэй 37-н айлын Хайбрид гарден хотхоны гадна тохижилт хийх	1,986.8	960.2
Нийт дүн			2,434.3	1,185.6

Мөн "Эрдэнэтэд үйлдвэрлэв" барилга барих 3,582.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2,000.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй зураг төсөвгүй ТАХ-г төлөвлөж, зураг төсвийн зардал 37.5 сая төгрөгийг давхар баталсан байна. Цаашид тухайн ТАХ-тэй

⁴ хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ;

холбоотой урсгал зардал, эдийн засгийн ач холбогдлыг тооцоолоогүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3.3⁵-т заасныг зөрчжээ.

Баян-Өндөр сумын ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны 21/02 дугаар тогтоолоор баталсан хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалтын 2.3.8-д баяр наадмын зардал 400.0 сая төгрөг батлагдсаны 131.9 сая төгрөгийг сумын 30 жилийн ойн арга хэмжээний бэлэг дурсгалын зүйл бэлтгэхэд зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.5⁶-т заасныг зөрчсөн байна.

Баян-Өндөр сумын ИТХ-ын 21/02 дугаар тогтоолоор баталсан хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалтын 2.3.13-т “Монгол уламжлалт тоглоом наадгайн сургалтын контент хийх”-д 20.0 сая төгрөг баталж, гүйцэтгэлээр “БТБ бүтээл” ХХК-аар гүйцэтгүүлж, санхүүжилтийг бүрэн олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.4⁷-т заасныг зөрчжээ.

Авто замын сангийн эх үүсвэрээр санхүүжих Авто зам, нийтийн эзэмшлийн гудамж талбайн цэвэрлэгээ, үйлчилгээ, арчилгаа тордолтын зардал /Давс, бодис/ худалдан авахад 400.0 сая төгрөг батлагдсаныг Хот тохижуулах газарт шилжүүлж, гүйцэтгэлээр 418.3 сая төгрөгийн давс бодис худалдан авч, 2024 оны 12 сарын 31-ний байдлаар 278.8 сая төгрөгийн үлдэгдэл байна.

Орхон аймаг нь 0.2 сая малтай, 1,072 малчин өрхийн өвөлжилт хүндэрсэн тохиолдолд онцгой комиссын зардал, ОНХС, болзошгүй аваарын зардал зэрэг 3 эх үүсвэрээс өвс тэжээлийн нөөц бэлтгэхэд нийт 763.6 сая төгрөг зарцуулж, оны эцэст 347.7 сая төгрөгийн үлдэгдэл байгаа нь өмнөх оноос 2 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Аймгийн хэмжээнд өвс тэжээлийн нөөц 2024.12.31-ний байдлаар

Хүснэгт 9

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Эхний үлд	Орлого	Зарлага	Эцсийн үлд
Жаргалант сум	49.6	251.7	214.6	86.7
Баян-Өндөр сум	50.0	49.99	49.99	50.0
ХХААГ	74.9	461.9	325.8	211.0
Нийт	174.5	763.59	590.39	347.7

⁵ техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ.

⁶ нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;

⁷ Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх;

Өвс тэжээлийн нөөц, давс бодисын нөөцийг ихээр бэлтгэж байгаа нь дараа онд ашиглалтын шаардлага хангахгүй болох эрсдэлтэй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.6⁸, Төсвийн тухай хуулийн 6.4.1⁹-т заасныг тус тус зөрчсөн байна.

Баян-Өндөр сумын иргэдийн ундны эх үүсвэрийг хамгаалахад шаардлагатай Naval Daego-X автомашины ашиглалтын байдлыг аудитын явцад шалгахад Дотоодын цэргийн 821-р ангийн захирагч нь хувийн хэрэгцээнд ашиглах зорилгоор улсын дугаарыг цэнхэр дугаараар солилгүй албаны бус зориулалтаар өдөр тутам ашиглаж байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.4¹⁰-т заасныг зөрчсөн байна.

БҮЛЭГ 2. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй 12 ТАХ-г хэрэгжүүлж, үнэлгээний хороо чанарын баталгаа, алданги тооцох хувь хэмжээг харилцан адилгүй шаардсан байна.

2.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, цахим системд мэдээлсэн байна.

ТБОНӨХБАҮХАТХ-ий 44.4¹¹-т заасны дагуу Засаг дарга Орхон аймгийн ТЕЗ-ийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, цахим системд нийтэлсэн байна.

Худалдан авах ажиллагааны 2024 оны жилийн төлөвлөгөөнд аймаг, сумдын хөрөнгө оруулалтын ТАХ-ний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр 139,270.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 134,395.5 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 736 ТАХ тусгажээ.

Худалдан авах ажиллагааны 2024 оны төлөвлөгөө

Хүснэгт 10

/сая төгрөгөөр/

№	Захиалагч	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	ХАА-нд баримталсан журам					
				НТШ	ХА	ШХА	ЕГБ	НЭҮХА	Нийт
1	Орхон аймгийн ЗД	106,533.0	101,977.9	164	107	51	-	2	324
2	Баян-Өндөр сумын ЗДТГ	15,572.9	15,572.9	28	94	93	-	-	215
3	Жаргалант сумын ЗДТГ	10,949.1	10,628.9	18	18	56	-	2	94
4	Хот тохижуулах газар	2,618.6	2,618.6	3	5	6	-	-	14
5	Эрдэнэт ус ДТС ОНӨХК	3,519.1	3,519.1	9	10	67	1	-	87
6	ЦНБГ	51.6	51.6	-	1	-	-	-	1
7	НҮА	26.5	26.5	-	1	-	-	-	1
Нийт дүн		139,270.8	134,395.5	222	236	273	1	4	736

⁸ нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх;

⁹ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

¹⁰ Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ.

¹¹ Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн жилийн санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш нэг сарын дотор харьяа захиалагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн хянаж, баталгаажуулан цахим системд нийтэлнэ.

Худалдан авах ажиллагааны 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлээр 129,870.2 сая төгрөгийн 725 гэрээ байгуулж, 3,956.1 сая төгрөгийн 21 тендер шалгаруулалт амжилтгүй болсон байна.

Худалдан авах ажиллагааны үр дүн

Хүснэгт 11

/сая төгрөгөөр/

№	Захиалагч	Төсөвт өртөг	Гүйцэтгэгч шалгарсан		Амжилтгүй болсон	
			Тоо	Гэрээний дүн	Тоо	Төсөвт өртөг
1	Орхон аймгийн ЗД	106,533.0	326	99,907.2	12	2,545.5
2	Баян-Өндөр сумын ЗДТГ	15,572.9	208	14,054.3	6	895.7
3	Жаргалант сумын ЗДТГ	10,949.1	94	10,534.4	-	-
4	Хот тохижуулах газар	2,618.6	13	2,432.8	1	39.6
5	Эрдэнэт ус ДТС ОНӨХК	3,519.1	82	2,864.7	2	475.3
6	ЦНБГ	51.6	1	50.6	-	-
7	НҮА	26.5	1	26.2	-	-
Нийт дүн		139,270.8	725	129,870.2	21	3,956.1

Аймгийн хэмжээнд зохион байгуулсан худалдан авах ажиллагаатай холбоотой Сангийн яаманд 34 гомдол, шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газарт 3 гомдол, нийт 37 гомдол гаргаснаас 19 гомдол нь ОНХО, авто замын сан, байгаль хамгаалах сан, Баян-Өндөр сумын хөрөнгө оруулалтад хамаарч байна.

Худалдан авах ажиллагааны гомдол шийдвэрлэсэн байдал

Хүснэгт 12

Харьяа ХАА-ны газар	Гомдлын тоо	Эзлэх хувь	Гомдол шийдвэрлэсэн байдал	Тоо
Аймгийн ХАА	25	67.6	Дахин хянах шаардлагатай	9
			Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй	6
			Захиалагчийн шийдвэр үндэслэлгүй	6
			Захиалагчийн шийдвэр хууль зөрчөөгүй	1
			Өрсөлдөөнийг хязгаарласан	3
БӨ сумын ХАА	8	21.6	Дахин хянах шаардлагатай	2
			Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй	1
			Захиалагчийн шийдвэр үндэслэлгүй	5
Жаргалант сумын ХАА	4	10.8	Дахин хянах шаардлагатай	1
			Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй	1
			Захиалагчийн шийдвэр үндэслэлгүй	2
Нийт дүн	37	100.0		37

Сангийн яам, Шударга өрсөлдөөний хэрэглэгчийн төлөө газар нь захиалагчийн шийдвэр үндэслэлгүй 13, дахин хянах шаардлагатай 12, захиалагчийн шийдвэр үндэслэлтэй, шийдвэр хууль зөрчөөгүй 9, өрсөлдөөнийг хязгаарласан 3 гомдлыг тус тус хянан шийдвэрлэжээ.

Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 01-ны өдрийн А/151 дүгээр захирамжаар Тагнуулын газарт ухаалаг самбар болон холбогдох тоног төхөөрөмж худалдан авах 200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг гүйцэтгэх эрхийг Тагнуулын

ерөнхий газрын Орхон аймаг дахь газарт шилжүүлж, санхүүжилтийг 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдөр бүрэн шилжүүлсэн байна.

2.2 Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын баталсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнээс 12 ТАХ-г ХАА-ны төлөвлөгөөнд тусгаагүй байна.

Худалдан авах ажиллагааны газар нь ОНХО, байгаль хамгаалах сан, авто замын сан, эрдэнэт сангийн эх үүсвэрээр санхүүжих 41,131.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 232 ТАХ-ний тендерийн баримт бичгийг боловсруулан батлуулж, тендер шалгаруулалт зохион байгуулсан байна.

Тендер шалгаруулалтын үр дүнгээр 237 аж ахуйн нэгжтэй 37,417.2 сая төгрөгийн гэрээ байгуулжээ.

Зохион байгуулсан худалдан авах ажиллагаа

Хүснэгт 13

/сая төгрөгөөр/

Эх үүсвэр	Цагалбар	Төсөвт өртөг	Гэрээний дүн	ХАА-ны төрөл			
				НТШ	ХА	ШХА	НЭҮХА
ОНХО	Шилжих	4,725.4	3,869.4	6	2	-	-
	Шинэ	32,346.0	30,465.1	73	72	9	2
Зөвлөх үйлчилгээ		2,471.9	1,664.1	4	11	41	-
БХС	Шинэ	369.6	236.2	1	2	-	-
АЗС	Шинэ	718.5	709.7	2	1	-	-
ЭТС	Шинэ	500.0	472.7	1	5	-	-
Дүн		41,131.4	37,417.2	87	93	50	2

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 09 дүгээр сарын 11-ны өдрийн 18/05 дугаар тогтоолоор баталсан хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан 5,141.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2,282.8 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 12 ТАХ-г ХАА-ны төлөвлөгөөнд тусгалгүй, тендер шалгаруулалт зохион байгуулаагүй байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагдаагүй ТАХ

Хүснэгт 14

/сая төгрөгөөр/

д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсөвт өртөг	2024 онд санхүүжих дүн	Тайлбар
2.1.36	Эрчим хүчний хэмнэлттэй Хайбрид амины орон сууц барих	54.9	54.9	Арга хэмжээний хүрээнд сугалаагаар иргэнийг тодруулж дулаан алдагдалгүй байшин барих төсөвт өртөг.
2.1.88	ОНӨГ-ын ажлын байрны засвар, тохижилт хийх /Урт цагаан, "Эрдэнэт Ус, ДТС" ОНӨХК-ийн байр/	61.7	61.7	Байршил өөрчлөгдсөн тул зураг төсвийг шинэчлэн 2025 онд шилжин хийгдэхээр болсон.
2.1.96	Авто вокзалын барилгад шилэн кабель татах	36.8	36.8	Говил баг руу шилэн кабель татах учраас нэг мөсөн нийтээр хийх болсон тул ажлыг гүйцэтгэхийг болиулсан.
2.1.95	Яргуйт, Баян-Овоот багийн байр болон 28-р цэцэрлэгийг халаалтын	750.0	750.0	НҮБ-тай 1.2 тэрбумын гэрээний орон нутгийн оролцооны мөнгө бөгөөд гүйцэтгэгч байгууллага нь

	нүүрстөрөгч багатай эх үүсвэртэй холбох / орон нутгийн оролцоо/			“Смарт энерги” ХХК, газрын гүний дулааныг ашиглахаар 27 цооног барьсан, 2025 оны 08 дугаар дуусах төлөвлөгөөтэй.
2.1.107	Эрдэнэ баг. Эрчим хүчний хэмнэлттэй 37-н айлын Хайбрид гарден хотхоны гадна тохижилт хийх	1,986.8	986.8	Орон нутгийн удирдлага газрыг нь шийдвэрлэж, цахилгаан эрчим хүч болон ИШС-г холбох асуудлыг шийдвэрлэж, 37 иргэнд 1 м.кв-ыг 2.9-3.3 сая төгрөгөөр худалдан борлуулах зорилготой.
2.1.109	8-р сургуулийн өргөтгөлийн барилгын спорт заалны шалыг засварлах	140.0	140.0	Сургуулийн өргөтгөл барьсан гүйцэтгэгчээр нэмэлт гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн.
2.1.111	Баянбулаг багт шинээр УДДТөв барих	1,958.4	100.0	Зураг төсөв хийгдээгүй. 2025 онд хийгдэнэ.
2.3.25	Эрдэнэт хотын түүх, дурсгалын ном гаргах	20.0	20.0	Юу хийх яах нь тодорхойгүй, техникийн тодорхойлолтгүй.
2.3.42	Баян-Өндөр цэцэрлэгт зөөлөн эдлэл худалдан авах	20.0	20.0	Урьдчилж бараагаа нийлүүлээд энэ оны төсөвт мөнгөө суулгасан.
2.3.43	Баян-Өндөр цэцэрлэгт хөнжил гудас худалдан авах	20.0	20.0	
2.3.44	Баян-Өндөр цэцэрлэгт хивс, дрож худалдан авах	63.2	63.2	
2.3.47	"Эрдэнэт ус, ДТС" ОНӨХК-д усны алдагдал тооцоолох DPCV маркийн даралт бууруулах хаалт худалдан авах	29.4	29.4	Техникийн тодорхойлолт байхгүй улмаас одоог хүртэл байхгүй.
Нийт дүн		5,141.2	2,282.8	

Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар аймгийн ИТХ, Засаг дарга нарт төлөвлөлтийн шаардлага хангасан зураг төсөвтэй, олон нийтийн саналыг авч эрэмбэлсэн, ач холбогдол бүхий, үр дүнг тооцсон ТАХ-г батлах зөвлөмж хүргүүлсэн ч хэрэгжээгүй байна. Тухайлбал:

Хөрөнгө оруулалтын ТАХ-нд 2,007.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 149.4 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 3 ТАХ-нь зураг төсөв, техникийн тодорхойлолтгүй төлөвлөгдсөн байна.

Эрдэнэтэд үйлдвэрлэв барилга барих 3,582.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2,000.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй төсөл арга хэмжээ нь төлөвлөлтийн шаардлага хангаагүй, иж бүрэн зураг төсөвгүй ТАХ-г баталж, зураг төсвийн зардал 37.5 сая төгрөгийг зөвлөх үйлчилгээний зардалд давхар баталсан нь Төсвийн тухай хуулийн 29¹.2.2¹² гэж заасныг зөрчсөн байна.

¹² барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх;

Иймд аймгийн ИТХ, Засаг дарга нарт хүргүүлсэн зөвлөмжийн биелэлт хангагдаагүй, зөрчил давтан гарсан байх тул зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

Баян-Өндөр цэцэрлэг шинээр ашиглалтад оруулахад шаардлагатай хэрэглэгдэхүүний төсвийг батлаагүйгээс Эрдэнэт сангийн эх үүсвэрт батлагдаагүй хивс дрожны үнэ 63.1 сая төгрөгийг 2024 оны 01 дүгээр сарын 29-нд шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 22.6.4¹³-т заасныг зөрчсөн байх тул зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 09 дүгээр сарын 11-ны өдрийн 18/05 дугаар тогтоолоор Баян-Өндөр цэцэрлэгтэй холбоотой 3 ТАХ-ны 103.2 сая төгрөгийг баталж, ЗД-ын А/712 дугаар захирамжаар 38.9 сая төгрөгийг 2024 оны 10 дугаар сарын 18-нд Баян-өндөр цэцэрлэгийн дансанд шилжүүлж, Эрдэнэт сангаас шилжүүлсэн 63.1 сая төгрөгийг ОНХО-ын данснаас 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдөр Эрдэнэт сангийн дансанд буцаан шилжүүлсэн нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 44.1¹⁴-т заасныг зөрчсөн байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 09 дүгээр сарын 11-ны өдрийн 18/05 дугаар тогтоолоор тодотгол орсонтой холбоотойгоор 3,312.8 сая төгрөгийн 34 ТАХ-ны тендер шалгаруулалт 2024 оны 11, 12 дугаар сард зохион байгуулагдаж, гэрээ байгуулагдсан нь тухайн ТАХ-үүд бүрэн хэрэгжээгүй, он дамнасан байна.

2.3 Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал 5 ТАХ-г 11 ТАХ болгон хуваан баталж, үнэлгээний хороо чанарын баталгаа алдангийг харилцан адилгүй шаардаж байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 09 дүгээр сарын 11-ны өдрийн 18/05 дугаар тогтоолоор баталсан хөрөнгө оруулалт ТАХ-ны жагсаалтад 5 ТАХ-г 11 ТАХ болгон төсөвт өртгийг хувааснаас 2 ТАХ-г өөр эх үүсвэрт баталжээ. Тухайлбал:

1. Уурхайчин багт Тамир зочид буудлын урд УДХТөв байгуулах 1,543.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 1,217.5 сая төгрөгийн санхүүжих дүнтэй ТАХ-г 3 хувааж анх 504.0 сая төгрөгөөр гэрээ байгуулж, 2024 онд 800.8 сая төгрөгөөр 2 дах ажлын тендерт шалгарсан бол 73.7 сая төгрөгөөр нэмэлт гэрээ байгуулжээ.
 - *УДХТ-ийг инженерийн шугам сүлжээнд холбох / дулаан механик / ТАХ-ны төсөвт өртөг 915.8 сая төгрөг,*
 - *УДХТөв байгуулах ТАХ-ний төсөвт өртөг 553.9 сая төгрөг.*

¹³ “төсөв батлах эрх бүхий байгууллага нь төсвийг шатлал бүрээр, түүнд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, тусгай сан, орлого, санхүүжүүлэх эх үүсвэр бүрээр нь батлах”

¹⁴ Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална.

- *УДХТөв байгуулах /нэмэлт ажлын санхүүжилт / төсөвт өртөг 73.7 сая төгрөг гэж 3 хуваасан.*
- 2. Уран эгшиг сургуулийн өргөтгөлийн барилга 2,130.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 1,575.1 сая төгрөгийн санхүүжих дүнтэй ТАХ-г 2 хувааж 1,853.0 сая төгрөгөөр анх 2023 онд гэрээ байгуулж, 2024 онд 15% буюу 277.9 сая төгрөгөөр нэмэлт гэрээ байгуулжээ.
 - *Уран эгшиг сургуулийн өргөтгөлийн барилга барих*
 - *Уран эгшиг сургуулийн өргөтгөлийн барилга барих /нэмэлт ажлын санхүүжилт/ гэж 2 хуваасан.*
- 3. Чингэл багт шинээр гэрэлтүүлэг хийх 458.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 458.5 сая төгрөгийн санхүүжих дүнтэй ТАХ-г 2 эх үүсвэрээс хувааж, тендер зохион байгуулан “Сервис по сименс” ХХК шалгарсан.
 - *Чингэл багт шинээр гэрэлтүүлэг хийх ОНХО-д 148.4 сая төгрөг*
 - *Чингэл багт шинээр гэрэлтүүлэг хийх ОНХС-д 310.1 сая төгрөг 2 эх үүсвэрт хуваан баталсан.*
- 4. Баян-Өндөр сумын 7-р сургуулийн спорт заалны засвар 445.0 сая төгрөгийн төсөвт өртөг, санхүүжих дүнтэй ТАХ-ний гүйцэтгэгчээр “Вилла проект” ХХК шалгарсан.
 - *7-р сургуулийн спорт заалны засвар хийх /шал, дээвэр, сантехник/ 325.0 сая.*
 - *7-р сургуулийн спорт заалны шалыг засварлах 120.0 сая төгрөг болгож 2 хуваасан.*
- 5. Баянбулаг баг. Гудамж хоорондын зам хийх /2 мөртэй зам/ ТАХ-ний гүйцэтгэгчээр
 - *Баянбулаг баг. Гудамж хоорондын зам хийх /2 мөртэй зам/ ОНХО-д 325.0 сая төгрөг.*
 - *Баянбулаг баг. Гудамж хоорондын зам хийх /2 мөртэй зам/ АЗСан-д 360.0 сая төгрөгөөр 2 хуваасан.*

Тоног төхөөрөмж:

- *Чөлөөт бөхийн холбоонд дэвжээ худалдан авах тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 18.1-т “ сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан ашигтай ажилласан байх” гэж тусгасан боловч тендерт шалгарсан “Арвилах” ХХК-ийн санхүүгийн чадавхыг үнэлэхдээ сүүлийн 2 жилийг бус 2021, 2022 оны санхүүгийн тайланг үнэлж, шалгаруулжээ.*
- *Замын арчилгааны тоног төхөөрөмж худалдан авах /асфальт зүсэгч, цагаан зураас будагч, трамбок/ тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтийн 19.1-т “ижил төстэй гэрээний туршлага:2022, 2023 онуудын аль нэг жилд доод тал*

нь нэг удаа батлагдсан төсөвт өртгийн 100 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй бараа нийлүүлсэн байх” гэж заасан байтал тендерт шалгарсан “Би Би кэй эйч” ХХК нь геодези зураг зүйн суурь судалгаа, үйлчилгээ хийдэг аж ахуйн нэгж бөгөөд асфальт зүсэгч, цагаан зураас будагч, трамбок зэрэг тоног төхөөрөмж нийлүүлсэн туршилагагүй аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулсан байна.

- Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж худалдан авах тендер шалгаруулалтын барим бичгийн 19.1-т “2022, 2023 оны аль нэг жилд доод тал нь нэг удаа батлагдсан төсөвт өртгийн 100 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй бараа нийлүүлсэн байх” гэж заасан байтал тендерт шалгарсан “Сүнжин гэрэлт” ХХК-нь цахилгаан гагнуурын аппарат, цамхагт гэрэл, суурин компьютер, 3 үйлдэлт принтер гэх мэт тоног төхөөрөмж нийлүүлсэн гэрээ ирүүлсэн нь ижил төстэй бараа нийлүүлсэн гэж үзэхээргүй аж ахуйн нэгжийг шалгаруулсан байна.

Аймгийн худалдан авах ажиллагааны газрын дотоод хяналтын шалгалтын мэргэжилтний 2024 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөнд ХАА-ны төлөвлөлт хууль журмын дагуу боловсруулагдсан эсэх, ТШББ-ийг хууль журмын дагуу боловсруулагдсан эсэх гэх мэт 12 хяналтыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хяналт шалгалтын үр дүнгээр ХАА-ын газрын 3 мэргэжилтэнд ижил утгатай 5 зөвлөмж, харьяа 5 байгууллагад ижил утгатай 12 зөвлөмжийг тус тус хүргүүлжээ. Хяналтын үр дүнгээр илэрсэн зөрчил дутагдлаас дурдахад:

Баян-Өндөр сумын ЗДТГ:

- ✓ Баян-өндөр сумын 182 ТАХ-ний ХАА-г төлөвлөснөөс 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн хяналтаар төсөв ирээгүй 81 ТАХ, техникийн тодорхойлолт ирээгүй 16, ажлын даалгавар ирээгүй 3 ТАХ байсан байна.

Жаргалант сумын ЗДТГ:

- ✓ Жаргалант сумын 62 ТАХ-ны ХАА-г төлөвлөснөөс 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар зураг төсөв ирээгүй 9 ТАХ, техникийн тодорхойлолт ирээгүй 3 ТАХ байна.

Дээрх илэрсэн зөрчил дутагдлаас үзэхэд зураг төсөвгүй, ажлын даалгаваргүй ТАХ-г төлөвлөх зөрчил дутагдал арилаагүй байсаар байгаа нь тухайн ТАХ төлөвлөсөн хугацаанд хэрэгжих боломжийг алдагдуулж, он дамнан хэрэгжих эрсдэлийг нэмэгдүүлсээр байна.

ХАА-ны газрын дотоод хяналт шалгалтын тайланд нийт хэдэн ТАХ-ны тендер шалгаруулалтын материалыг хамруулсан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаа хуулийн дагуу зохион байгуулагдсан эсэх, хүргүүлсэн зөвлөмжийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх нотлох баримт хангалтгүй байна.

Иймд ХАА-ны газар нь дотоод хяналт шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тодорхой тооцож байх шаардлагатай байна.

Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар өгсөн төлөвлөлтийн шаардлага хангасан зураг төсөвтэй, олон нийтийн саналыг авч эрэмбэлсэн, ач холбогдол бүхий үр дүнг тооцсон ТАХ-г төлөвлөх гэсэн зөвлөмж хэрэгжээгүй байх тул Баян-Өндөр сумын ИТХ, Засаг дарга, Жаргалант сумын ИТХ, Засаг дарга нарт зөрчил арилгах албан шаардлага хүргүүлэв.

Ашиглагч байгууллага Япон, ОХУ-д үйлдвэрлэгдсэн машин, тоног төхөөрөмжийг авахаар техникийн тодорхойлолтыг нарийвчлан боловсруулж, захиалагчид хүргүүлсэн байна. Гэсэн хэдий ч зарласан тендерийн техникийн тодорхойлолтод хуулийн 12.4¹⁵, 12.5¹⁶ заалтын дагуу үйлдвэрлэгчийг тусгайлан заахгүй, эсхүл түүнтэй дүйцэх гэсэн тодотгол хэрэглэж байгаагаас БНХАУ-д үйлдвэрлэгдсэн машин техник нийлүүлэгдсэн нь Монголын нөхцөлд бүрэн ажиллах боломжгүй, чанарын шаардлагыг бүрэн хангахгүй, эвдрэл гэмтэл ихтэй, сэлбэг хэрэгсэл олдохгүй нөхцөл байдал үүсч байна. Тухайлбал:

- *"ЭУДТС" ОНӨХК-нд тусгай зориулалтын техник худалдан авах / ус зөөврийн авто машин 2, сагстай өргөгч авто машин 2, бохир ус зөөврийн авто машин 1, универсал трактор 1/*
- *ХТГ-т Зам талбай цэвэрлэх зориулалттай олон үйлдэлт авто машин, тусгай зориулалтын техник хэрэгсэл худалдан авах /авто грейдер 1, индүү 4тн 1, ковш 1, тусгай зориулалтын 1 авто машин/*

Иймд ХАА-ны газар тусгай зориулалтын техник хэрэгсэл нийлүүлэх тендер шалгаруулалт зохион байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн 42.5¹⁷-т заасны дагуу баталгааны хугацаанд чанарын баталгааг барьцаалж, гэрээний үүргийн биелэлтийг бүрэн хангуулсны дараа чанарын баталгааг олгож байх шаардлагатай байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 09 дүгээр сарын 11-ны өдрийн 18/05 дугаар тогтоол, Баян-Өндөр сумын ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны 21/02 дугаар тогтоолоор баталсан хөрөнгө оруулалт жагсаалтад батлагдсан 603.3 сая төгрөгийн 4 ТАХ нь батлагдсан нэршлээс өөрөөр техникийн тодорхойлолт

¹⁵ Техникийн тодорхойлолтод тодорхой нэг аж ахуй эрхлэгчийн бараа, үйлчилгээний худалдааны нэр, патент, түүнийг эзэмшигч, үйлдвэрлэгч, нийлүүлэгч, эсхүл үйлдвэрлэлийн арга, гарал үүслийг тухайлан заахыг хориглоно.

¹⁶ Техникийн тодорхойлолтыг нарийвчлан тодорхойлох боломжгүй бол энэ тухай үндэслэл бүхий тайлбарыг дурдсаны үндсэн дээр зөвхөн тухайн бараанд холбогдуулан энэ хуулийн 12.4-т заасан шаардлага, нөхцөлийг тавьж болох бөгөөд энэ тохиолдолд "эсхүл түүнтэй дүйцэх" гэсэн тодотгол хэрэглэнэ.

¹⁷ Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаа болон зүгшрүүлэх, тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор захиалагч худалдан авах гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг барьцаалах нөхцөлийг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгаж болно.

боловсруулагдаж, батлагдсан нэршилтэй нийцэхгүй тээврийн хэрэгсэл нийлүүлэгдсэн байна.

Батлагдсан нэршилтэй нийцэхгүй ТАХ

Хүснэгт 15

/сая төгрөгөөр/

Эх үүсвэр	ТАХ-ний нэр	Төсөвт өртөг	Нийлүүлэгдсэн нь
ОНХО	Авто тээврийн төвд явуулын оношилгооны авто машин худалдан авах	70.0	Явуулын оношилгоо хийгдэх боломжгүй, энгийн соната-10 машин 65.9 сая төгрөгөөр нийлүүлэгдсэн.
	Үерийн гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, үерийн далан суваг шуудууг сэргээн засварлах ажлын хүрээнд тоног төхөөрөмж худалдан авах / ус соруулах мотопомп-3	188.3	Ус соруулах чадваргүй, форд маркийн векап жийп 82.0 сая төгрөгөөр нийлүүлэгдсэн байна.
Баян-Өндөр сумын ОНХО	Хот тохижуулах газарт цас, мөс шүүрдэж цэвэрлэх тусгай хэрэгцээт авто машин	165.0	Старекс, портер, вонго маркийн машин
	Баян-Өндөр сумын иргэдийн ундны эх үүсвэрийг хамгаалахад шаардлагатай автомашин худалдан авах	180.0	Хятад улсад үйлдвэрлэгдсэн Ховал үйлдвэрийн жийп, старекс гранд маркийн тээврийн хэрэгсэл нийлүүлэгдсэн.
Нийт дүн		603.3	

Иймд ИТХ-аар баталсан нэршилд нийцүүлэн техникийн тодорхойлолтыг боловсруулан батлуулж, тендер шалгаруулалтыг зохион байгуулж байх талаар захиалагчид зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлэв.

БҮЛЭГ 3. Хэрэгжиж дууссан ТАХ-г гүйцэтгэл, хүлээн авсан баримтад үндэслэн санхүүжилтийг олгож, зураг төсөвгүй, техникийн тодорхойлолтгүй ТАХ баталж байгаа нь хугацаандаа хэрэгжүүлэх боломжийг алдагдуулжээ.

3.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлийн санхүүжилтэд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний нийт гүйцэтгэлд 48,213.0 сая төгрөгийг 7 эх үүсвэрээс олгосон байна.

Санхүүжилт олгосон мэдээлэл

Хүснэгт 16

/сая төгрөгөөр/

Эх үүсвэр	Гүйцэтгэгчид олгосон	Магадлашгүй ажилд	Захиалагчийн хяналт	Зохиогчийн хяналт	Барьцаа 5%	Алданги	Нийт
Аймгийн ОНХО	37,375.1	251.8	388.9	495.9	719.5	73.1	39,304.4
АЗСан	644.2	6.0	20.0	16.6	33.2		719.9
ЭТСан	454.0	-	4.5	5.8	8.1	0.4	472.7
Аймгийн БХС	2,304.7	-	4.0	8.0	125.8	69.6	2,512.1
БӨ ОНХО	627.8	-	17.5	8.7			654.1
БӨ БХС	2,013.1	27.5	33.1	62.8	79.5		2,216.0

Жар ОНХО	4,794.1	70.7	71.3	92.7	208.5		5,237.3
Нийт	48,213.0	356.0	539.2	690.5	1,174.6	143.0	51,116.3

Тайлант онд хэрэгжүүлсэн 43 ТАХ-ээс нийт 143.0 сая төгрөгийн алдангийг суутган тооцсон байна. Үүнд:

- Аймгийн ОНХО-ын 39 ТАХ-ээс 73.1 сая төгрөг,
- Аймгийн БХС-ийн 1 ТАХ-ээс 69.5 сая төгрөг,
- Эрдэнэт сангийн 3 ТАХ-ээс 0.4 сая төгрөг.

Магадлашгүй ажлын зардлаас 51 ТАХ-нд 356.0 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгожээ. Үүнд:

- ОНХО-ын 42 ТАХ-нд 251.8 сая төгрөг,
- АЗСангийн 1 ТАХ-нд 5.9 сая төгрөг,
- Баян-Өндөр сумын БХС-ийн 4 ТАХ-нд 27.5 сая төгрөг,
- Жаргалант сумын ХО-ын 4 ТАХ-нд 70.7 сая төгрөг.

Тайлант онд хэрэгжүүлсэн 58 ТАХ-ний 1,174.6 сая төгрөгийн барьцааны баталгааг суутган гүйцэтгэгчид олгожээ. Үүнд:

- ОНХО-ын 43 ТАХ-ний 719.5 сая төгрөг,
- БХС-ийн 3 ТАХ-ний 125.8 сая төгрөг,
- АЗС-ийн 2 ТАХ-ний 33.2 сая төгрөг,
- Эрдэнэт сангийн 1 ТАХ-ний 8.1 сая төгрөг,
- Баян-Өндөр сумын БХС-ийн 4 ТАХ-ний 79.5 сая төгрөг,
- Жаргалант сумын ОНХО-ын 5 ТАХ-ний 208.5 сая төгрөг.

Санхүүжилт олгосон байдлыг хүснэгтээр харуулбал

Хүснэгт 17

/сая төгрөгөөр/

Эх үүсвэр	Магадлашгүй ажил		Барьцаа 5%		Алданги	
	ТАХ-ний тоо	Мөнгөн дүн	ТАХ-ний тоо	Мөнгөн дүн	ТАХ-ний тоо	Мөнгөн дүн
Аймгийн ОНХО	42	251.80	43	719.5	39	73.1
АЗСан	1	5.97	2	33.2	-	-
ЭТСан	-	-	1	8.1	3	0.4
Аймгийн БХС	-	-	3	125.8	1	69.5
БӨ ОНХО	-	-	-	-	-	-
БӨ БХС	4	27.52	4	79.5	-	-
Жар ОНХО	4	70.70	5	208.5	-	-
Нийт	51	356.0	58	1,174.6	43	143.0

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 09 дүгээр сарын 11-ны өдрийн 18/05 дугаар тогтоолд хөрөнгө оруулалтын жагсаалтад 9 ТАХ-ний баталгаа 5% болох 152.5 сая төгрөгийг олгохоор баталсан байна.

Хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан баталгаа

Хүснэгт 18

/сая төгрөгөөр/

Эх үүсвэр	д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Төсөвт өртөг	2024 онд санхүүжих дүн
ОНХО	1.1.22	Зэст баг. 1-3.4-р байрны гадна авто зогсоолын өргөтгөл хийх / баталгааны 5 хувь /	2021	2024	37.4	1.3
	1.1.23	Зэст баг. 1-5,6-р байрны гадна авто зогсоолын өргөтгөл хийх / баталгааны 5 хувь /	2021	2024	52.6	2.2
	1.1.24	4-20-р байрнаас 4-14-р байр хүртэлх авто замд карма зогсоол хийх / баталгааны 5 хувь /	2021	2024	34.0	1.7
	1.1.25	Уурхайчин баг. 3-р хорооллын 12-р байрны авто зогсоолын өргөтгөл, 3-р хорооллын 22-р байрны автозамын өргөтгөл, Уурхайчны гудамжнаас Одод цэцэрлэг хүртэлх автозамын гарцыг өргөтгөх / баталгааны 5 хувь /	2021	2024	52.3	2.6
	1.1.27	Булаг баг, 1-р гудамжны ар талын талбайд амралт чөлөөт цагийн талбай байгуулах ажил / баталгааны 5 хувь /	2023	2024	42.1	2.1
	1.1.28	Согоот баг, 6-13-р байрны цэвэр усны шугам сольж шинэчлэх ажил / баталгааны 5 хувь /	2023	2024	87.0	4.4
	1.1.29	Номын өргөө бүхий цогцолбор барилга / баталгааны 5 хувь /	2021	2024	4,655.9	128.9
АЗС	1.1.3	Баянбулаг, Булаг багийн нутаг дэвсгэрт ус түгээх 2-р цэг хүртэлх 0.700 км хатуу хучилттай авто зам барих /Баталгааны 5 хувь /	2021	2024	133.2	6.7
	1.1.4	Хотын доторх авто замын нөхөөс хийх / Баталгааны 5 хувь /	2021	2024	54.6	2.7
Нийт дүн					5,149.1	152.5

Хөрөнгө оруулалтын барьцааны 100210000350 дугаарын данс нь 2018 оны 09 дүгээр сараас хойш ашиглаж эхэлсэн байхад дээрх 9 ТАХ-ний баталгааны 5%-ийг суутгаж, тус дансанд байршуулаагүй байна. Энэ нь "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.2.2.5-д "төсөл, арга хэмжээний техник, технологийн хяналтын зардал болох захиалагчийн хяналт, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн техник хяналтын дансанд, чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд, зураг төслийн үнэ, нормчлолын сангийн зардлыг тус тусын дансанд холбогдох гэрээ, баримт бичиг, акт зэргийг үндэслэн шилжүүлэх" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд аймгийн ЗДТГ-ын СТСХ бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, хөрөнгө оруулалтын барьцаа дансны үлдэгдлийг ТАХ тус бүрээр тооцоо нийлж, баталгааны 5%-ийг хөрөнгө оруулалтын барьцаа данснаас олгож байх хэрэгтэй байна.

Хөрөнгө оруулалтын санхүүжилттэй холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аймгийн хөрөнгө оруулалт:

- Уртын гол багт баригдаж байгаа 260 айлын 5 блок орон сууцны цогцолборын ажил ТАХ-ний гүйцэтгэлийн санхүүжилтээс захиалагчийн болон зохиогчийн хяналтын зардалд олгогдох 27.8 сая төгрөгийг гүйцэтгэгчээс тухай бүр суутгалгүй дараагийн гүйцэтгэлийн санхүүжилтээс нөхөн суутгасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1¹⁸, 37.1.1¹⁹, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.2.2.5²⁰-д заасныг зөрчсөн байх тул албан шаардлага хүргүүлэв.
- Номын өргөө бүхий цогцолбор барилга төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилтээс чанарын баталгаа 150.0 сая төгрөгийг 1 жил дуусаагүй байхад гүйцэтгэгчид олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 2.9-д "Хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн зардлын эрх олгох журам", 2.9.1²¹, 2.9.2²²-т заасныг зөрчсөн байх тул төлбөрийн акт тогтоов.
- "Эрдэнэтэд үйлдвэрлэв" төвийн барилгын зураг төсөл боловсруулах ТАХ-а хүчин төгөлдөр бус баримтад үндэслэн 0.8 сая төгрөгийн алдангийг дутуу суутган, санхүүжилтийг олгосон байна. Энэ нь "Эрдэнэтэд үйлдвэрлэв" төвийн барилгын ажлын зураг төсөл боловсруулах үйлчилгээ үзүүлэх ЗТБ-02/24 дугаартай гэрээний 9.13²³-т заасныг зөрчсөн байх тул төлбөрийн акт тогтоов.

Баян-Өндөр сумын хөрөнгө оруулалт:

- Баян-Өндөр сумын БХС-ийн 3 ТАХ-ний баталгааны 5% болох 12.3 сая төгрөгийг суутган тооцолгүй гүйцэтгэгчид санхүүжилтийг 100 хувь олгосон байна.

¹⁸ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

¹⁹ төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, түүнд хяналт тавих;

²⁰ төсөл, арга хэмжээний техник, технологийн хяналтын зардал болох захиалагчийн хяналт, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн техник хяналтын дансанд, чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд, зураг төслийн үнэ, нормчлолын сангийн зардлыг тус тусын дансанд холбогдох гэрээ, баримт бичиг, акт зэргийг үндэслэн шилжүүлэх;

²¹ Төсвийн захирагч буюу захиалагч нь хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн зардлын эрх нээлгэх хүсэлтийг энэ журмын 27 дугаар хавсралтад заасан маягтын дагуу баталгаажуулан гэрээ, комиссын дүгнэлт, ашиглагч байгууллагын тодорхойлолтын хамт харьяа төрийн санд хүргүүлнэ;

²² Энэ журмын 2.9.1-д заасан төрийн сан нь хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн зардлын эрхийг төсвийн захирагч буюу захиалагчийн шийдвэр, хууль болон гэрээнд заасан холбогдох заалтыг үндэслэн олгоно;

²³ Үйлчилгээг үзүүлэх явцад болон үйлчилгээ үзүүлсэнтэй холбоотойгоор гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсэн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана. Гүйцэтгэгч нь ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй, хугацаа сунгах хүсэлтээ гэрээний хугацаа дуусахаас өмнө 5 хоногийн дотор өгч шийдвэрлүүлээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутам гэрээний үнийн 0.1 хувь хэмжээгээр алдангийг захиалагчид төлнө

Төсөл хөтөлбөрийн зардалд нийт 19,122.4 сая төгрөгийн 243 ТАХ батлагдсанаас 17,247.7 сая төгрөгийн 235 ТАХ-г санхүүжүүлж, 200.9 сая төгрөгийн 8 ТАХ огт хэрэгжээгүй тул санхүүжилт олгогдоогүй байна.

Төсөл, хөтөлбөрийн зарцуулалтын задаргаа

Хүснэгт 19

/сая төгрөгөөр/

Эх үүсвэр	ТАХ-ний тоо	2024 онд санхүүжих дүн	Гэрээний дүн	Нийт олгосон
Аймгийн Тө.хөт	184	12,986.1	11,802.1	11,802.1
АЗСан	3	1,243.5	1,243.5	1,046.8
БХСан	17	979.9	879.6	857.5
БӨ сум	16	1,945.3	1,632.6	1,586.2
Жар сум	13	1,929.5	1,925.5	1,925.4
ЭТСан	2	38.1	38.1	29.7
Нийт дүн	235	19,122.4	17,521.4	17,247.7

Төсөл хөтөлбөрийн зардлын санхүүжилттэй холбоотой 13.1 сая төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоов. Үүнд:

- "Хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хамтарсан багийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх" төсөл хөтөлбөрийн хүрээнд "Итгэл дүүрэн гэр" бүл сэтгэл зүйн үйлчилгээ, архинд донтох эмгэгтэй 50 иргэнийг эмчилгээнд хамруулах зорилгоор Оюу сэтгэц наркологийн эмнэлгийн дансанд анхан шатны баримтын бүртгэлгүй 6.4 сая төгрөгийг шилжүүлсэн.
- "Баян-Өндөр уул болон 7 бурхан одны тахилга" хийх арга хэмжээний зардлаас 0.2 сая төгрөгийн архи, согтууруулах ундаа худалдан авч зарцуулсан.
- Хувийн хэвшлийн "Бяцхан одод" цэцэрлэгт зуны улиралд чийрэгжүүлэлтийн бүлэг ажиллуулахад анхан шатны баримтын бүрдэлгүй 2.3 сая төгрөгийг олгосон.
- Орхон аймгийн Засаг даргын 2024 оны 07 сарын 04-ний өдрийн А/500 дугаар захирамжаар "Эрдэнэтчүүд Эрдэнэтчүүддээ хайртай хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал"-аас "Эрдэнэтэд төгсөгчдийн холбоо" НҮТББ-ын дансанд анхан шатны баримтын бүрдэлгүй 4.2 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

Төсөл хөтөлбөрийн зардлын санхүүжилттэй холбоотой 115.9 сая төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага, 40.0 сая төгрөгийн 1 зөрчилд сахилгын хариуцлага тооцох албан шаардлага тус тус хүргүүлэв. Үүнд:

- Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн аудитаар өгсөн Гэр бүлийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх, сэтгэлзүйн төв ажиллуулах, сургалт нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах зорилгоор "Эрдэнэт академи" НҮТББ-тай 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 49/23 дугаартай хамтран ажиллах гэрээ байгуулсан боловч гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй, гэрээ дүгнэлгүй 40.0 сая төгрөгийн

санхүүжилт олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлсэн боловч биелээгүй байх тул сахилгын хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

- "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын 45 жилийн ойн хүндэтгэлийн арга хэмжээнд Орхон аймгийн Засаг дарга оролцох үеэрээ сугалаа зохион байгуулж, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ажилтны "Парис-2024" олимп үзэх замын зардал 15.9 сая төгрөгийг төсөл, хөтөлбөрийн зардлаас олгосон.
- Тайлант онд Булган аймгийн 5 сумын тэгш ой тохиож буйтай холбоотой 100.0 сая төгрөгийн дэмжлэг олгосон.

3.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зураг төсөвгүй, техникийн тодорхойлолтгүй ТАХ баталсан нь хугацаандаа хэрэгжүүлэх боломжийг алдагдуулж байна.

Аймгийн хөрөнгө оруулалтаар шилжих үлдэгдэлд 57,898.3 сая төгрөгийн 47 ТАХ-г 20,270.1 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 16,744.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 26 ТАХ бүрэн хэрэгжиж дуусан гэрээг дүгнэсэн, 40,956.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 19 ТАХ хэрэгжилт дутуу 40-90 хувийн гүйцэтгэлтэй, огт хэрэгжээгүй 197.1 сая төгрөгийн 2 ТАХ байна.

Шилжих үлдэгдлээр батлагдсан ТАХ-ээс ажлын гүйцэтгэл 90-100 хувьтай 1,363.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй 6 ТАХ дараах шалтгааны улмаас хүлээлгэн өгөөгүй, гэрээ дүгнэх ажил хийгдээгүй он дамнасан байна. Үүнд:

- Уртын гол багт жишиг гудамж тохижуулах, 6-р хорооллын 10-р байрны явган хүний зам шинэчлэх 2 ТАХ нь гүйцэтгэл бүрэн дуусаж комисс хүлээн авсан боловч гүйцэтгэгч байгууллага баримт бичиг бүрдүүлэлтээ хийгээгүй.
- Цагаанчулуут баг, Эко хорооллын баруун талд УДХТөв барьж хэрэглэгчдийг холбох нөхцөл бүрдүүлэх, 11-р хорооллын 2х2000 м3-ийн усан санг ашиглалтад оруулах үлдэгдэл санхүүжилт 2 ТАХ нь 95-100%-ийн гүйцэтгэлтэй боловч ашиглагч талын шаардлагыг гүйцэт биелүүлээгүйн улмаас бүрэн хүлээлгэж өгөөгүй байна.
- Уурхайчин багт Тамир зочид буудлын урд УДХТөв байгуулах ТАХ нь гүйцэтгэгч дулааны улиралд хийх ажлыг оройтож эхэлснээс шалтгаалж тухайн ондоо бүрэн дуусаагүй, 2025 оны 06 сард хүлээлгэж өгөх төлөвлөгөөтэй.
- Дэнж баг, Баруун дэнж хэсэгт амралт чөлөөт цагийн талбай байгуулах ажил ТАХ тоглоомын талбайг бүрэн тохижуулж, хүлээн авах комиссын шаардлага биелээгүй байтал хүйтний улирал эхэлж, 2024 оны хавар хүлээлгэн өгөхөд суурилуулсан тоног төхөөрөмж, тоглоомууд нь эвдэрч, зарим нь алга болсон тул хүлээн авах боломжгүй нөхцөл бүрдэж, гүйцэтгэгч Цагдаагийн байгууллагад хандсан.

- *Эрдэнэт сангийн эх үүсвэрээр шилжих үлдэгдлээр батлагдсан 6,499.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 ТАХ 80-90% хувийн гүйцэтгэлтэй боловч он дамнасаар байна.*
- *Эрдэнэт сангийн үүсвэрээр Эрдэнэ багийн усан санд өргөлтийн насос нэмж суурилуулах ТАХ нь суурилуулсан насос туршилт тохируулгын үед эвдэрч дахин засварлах, шинэ насос захих ажлуудаас хамаарч удааширсан байна.*
- *Цэцэрлэгт хүрээлэнгийн хөрөнгө оруулалтын ажлын нэмэлт санхүүжилт ТАХ нь тоглоом бүрэн суурилуулагдаж, туршилт тохируулга хийгдсэн, цахилгааны эх үүсвэр байхгүй тул ашиглах боломжгүй.*
- *“Цэцэрлэгт хүрээлэн”-ийн хөрөнгө оруулалтын ажлын нэмэлт санхүүжилт гүйцэтгэгч Сокол ХХК-тай 2020 оны 06 дугаар сарын 16-нд түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээ байгуулагдсан, тоног төхөөрөмж ирсэн боловч угсрах ажил хийгдээгүй, ХББЗА ОНӨААТҮГ-аас ХЭЗХ-т 2024 оны 10 дугаар сарын 08-нд шилжүүлсэн боловч одоог хүртэл арга хэмжээ аваагүй.*
- *Орхон аймаг дахь орон сууцны 1А хорооллын дэд бүтэц барих ТАХ нь тоног төхөөрөмж ирж угсрагдсан боловч автоматжуулалтын ажил хийгдээгүй, гүйцэтгэгч байгууллага 2024 оны 06 дугаар сараас хойш гэрээ сунгаагаагүй байдалтай байна.*

Баян-Өндөр сумын БХС-ийн эх үүсвэрээс 3,127.1 сая төгрөгийн 22 ТАХ-ээс 2,256.1 сая төгрөгийн 18 ТАХ бүрэн хэрэгжиж дууссан, 871.2 сая төгрөгийн 4 ТАХ худалдан авах ажиллагаа оройтож зохион байгуулагдсан, зураг төсөвт өөрчлөлт орох болсноос шалтгаалж хэрэгжээгүй байна.

Баян-Өндөр сумын хөрөнгө оруулалтаар 1,184.0 сая төгрөгийн 10 ТАХ төлөвлөснөөс 594.0 сая төгрөгийн 7 ТАХ бүрэн хэрэгжиж дууссан, 590.0 сая төгрөгийн 3 ТАХ, Жаргалант сумын хөрөнгө оруулалтаар хэрэгжих 3,378.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 25 ТАХ төлөвлөснөөс 1,408.2 сая төгрөгийн 23 ТАХ хугацаандаа бүрэн хэрэгжиж гэрээ дүгнэсэн, 1,969.8 сая төгрөгийн 2 ТАХ оны эцэст гэрээ хийгдэж, он дамнасан хэрэгжиж байна.

Орхон аймгийн хэмжээнд 60,301.6 сая төгрөгийн 32 ТАХ хэрэгжилт дутуу, 13,933.4 сая төгрөгийн 46 ТАХ хэрэгжээгүй байгаа нь зураг төсөв бүрэн батлагдаагүйгээс худалдан авах ажиллагаа оройтож зарлагдах, гүйцэтгэгч байгууллага ажлаа дулааны улиралд эрт эхлүүлэхгүй байх зэргээс хамаарч ажил удаашрах эрсдэл байсаар байна.

Өмнөх оны хөрөнгө оруулалтын аудитаар 2020 онд баталсан 3 ТАХ одоо болтол дуусаагүй, дуусгах арга хэмжээ авахгүй, шилжих үлдэгдлээр баталсаар байгаа зөрчилд 104/А1460335 дугаарын албан шаардлагыг Засаг даргад хүргүүлсэн боловч хэрэгжилт хангагдаагүй байна. Тухайлбал:

- *Эрдэнэт сангийн эх үүсвэрээс дараах 3 төсөл арга хэмжээ жил бүр батлагддаг боловч одоог хүртэл дуусаагүй байсаар байна.*

Зураг 1

	<p>Цэцэрлэгт хүрээлэнгийн хөрөнгө оруулалтын ажлын нэмэлт санхүүжилт 1,629.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8.7 сая төгрөгийн санхүүжих дүнтэй гүйцэтгэгчээр Легато констракшин ХХК 2020 оноос хойш дуусаагүй 1,620.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Сокол ХХК-ийн гүйцэтгэж буй Цэцэрлэгт хүрээлэнгийн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөв боловсруулагдаж дуусаагүйгээс шалтгаалж тус ажлыг хүлээн авах боломжгүй хүлээгдэж байгаа.</p>
	<p>“Цэцэрлэгт хүрээлэн”-ийн хөрөнгө оруулалтын ажлын нэмэлт санхүүжилт гүйцэтгэгч Сокол ХХК-тай түлхүүр гардуулах нөхцөлтэй 2020 онд ТГ-02/20 гэрээ байгуулж, НГ-07/22 нэмэлт гэрээ хийж, 2023 оны 07 дугаар сарын 01-нд дууссан. Цэцэрлэгт хүрээлэнгийн ерөнхий төлөвлөгөөний зургийг боловсруулсан боловч магадлалаар орох эсэхийг эцэслэж шийдвэрлээгүй, зураг төсвөө хүлээлгэж өгөөгүйтэй хамааралтай тоглоом угсралтын хийгдэхгүй ажил зогссон. ХББЗА ОНӨААТҮГ-ын газраас ХЭЗХ-т 4 удаа албан бичиг хүргүүлсэн боловч одоог хүртэл тодорхой шийдвэр гаргаж хууль хяналтын байгууллагад шилжүүлээгүй.</p>
	<p>Орхон аймаг дахь орон сууцны 1А хорооллын дэд бүтэц барих ажил 2020 оноос хойш төлөвлөгдөж, сүүлийн 2 жил юу ч хийгдээгүй, нийт гэрээний дүн 9,989.9 сая төгрөг, гүйцэтгэлээр санхүүжилт 8,400.0 сая төгрөг, Захиалагчаас хамааралтай 2 асуудлыг шийдвэрлээгүй, ХЭЗХ гэрээ цуцлах мэдэгдэл хүргүүлсэн.</p>

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар он дамнан хийгдэж буй ТАХ-г яаралтай хугацаанд нь дуусгах талаар үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй байх тул хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулахаар шийдвэрлэв.

3.3.Техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авсан ч чанарын баталгааг шаардахгүй нь гэрээний үүргийн биелэлтийг бүрэн хангуулахгүй байх нөхцөл бүрджээ.

Аймгийн хөрөнгө оруулалтаар 4,061.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 3,762.6 сая төгрөгийн 27 ТАХ нь 22 баг, ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын гадна камержуулалтыг хийж гүйцэтгэн, Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн нэгдсэн программын системд бүрэн холбогдсон байна.

Камержуулалт хийх 3,664.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй 26 ТАХ-ний хүрээнд нийт 572 камер суурилуулснаас аудитын явцад үзэхэд 99 камер ажиллахгүй байсан

бөгөөд ашиглагч байгууллага гүйцэтгэгчид шаардлага хүргүүлж, засварлахыг хүсдэг ч ирж засварлах нь ховор байдаг байна.

Аймгийн хөрөнгө оруулалтаар зам тээвэр, гэрэлтүүлгийн тусгай зориулалттай 2,995.0 сая төгрөгийн төсөвт өртөг, 2,871.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй 3 ТАХ-ний хүрээнд Хот тохижуулах газарт 1,664.8 сая төгрөгийн өртөгтэй 7 тээврийн хэрэгсэл, Эрдэнэт ус ДТС ОНӨХК-д 1,206.6 сая төгрөгийн өртөгтэй 7 тээврийн хэрэгсэл нийлүүлэгдсэн байна.

Төсөл, хөтөлбөрийн зарцуулалтын задаргаа

Хүснэгт 20

/сая төгрөгөөр/

Төсөл арга хэмжээний нэр	2024 онд төсөвт өртөг	Гэрээний дүн
Авто замын цэвэрлэгээний тусгай зориулалтын техник хэрэгсэл худалдан авах / 3ш /	405.00	398.90
ХТГ-т Зам талбай цэвэрлэх зориулалттай олон үйлдэлт авто машин, тусгай зориулалтын техник хэрэгсэл худалдан авах /авто грейдер 1, индүү 4тн 1, ковш 1, тусгай зориулалтын 1 авто машин/	1,330.00	1,265.88
ЭУДТС ОНӨХК-нд тусгай зориулалтын техник худалдан авах / ус зөөврийн авто машин 2, сагстай өргөгч авто машин 2, бохир ус зөөврийн авто машин 1, универсал трактор 1/	1,260.00	1,206.60
Нийт дүн	2,995.00	2,871.38

Дээрх 3 ТАХ-ний 14 тээврийн хэрэгслээс Хот тохижуулах газрын 398.9 сая төгрөгийн 3 тусгай зориулалтын техник хэрэгсэл нь Хятад улсын OFAC үйлдвэрийн, хүлээлгэн өгөхөд эвдрэл гэмтэлтэй ирснийг засуулж авсан, хүчин чадал муутай, сэлбэг хэрэгсэл олддоггүй, одоо ашиглалтын шаардлага хангахаа больж бүрэн зогссон байдалтай байна. Ашиглагч талаас нийлүүлэгчид шаардлага тавьсан боловч тодорхой шийдэлд хүрэлгүй өдийг хүрсэн байна.

Эрдэнэт ус ДТС ОНӨХК-ийн 161.3 сая төгрөгийн өртөгтэй 1 ширхэг Цэвэр ус зөөвөрлөх автомашин нь ашиглалтын шаардлага хангахгүй эвдэрсэн байдалтай байна.

Зураг 2 ХТГ-ын машин



Зураг 3 Эрдэнэт ус ДТС ОНӨХК машин



Тендер шалгаруулсан үнэлгээний хороо камержуулалтын ажил болон дээрх тусгай зориулалтын тээврийн хэрэгслээс чанарын баталгаа шаардаагүй, ажил бүрэн дуусаж хүлээлгэн өгч, комиссын акт гарсан бол санхүүжилтээ 100% авч буй нь хөрөнгө

оруулалтын үр өгөөжийг бууруулах, гэрээний үүргийн биелэлт бүрэн хангагдахгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.

Иймд төсөвт өртөг өндөр, тусгай хэрэгцээний, туршилт тохируулгын хугацаа шаардах ТАХ-ээс чанарын баталгааг зайлшгүй шаардаж, гэрээний үүргийн биелэлтийн бүрэн хангуулж, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулах шаардлагатай байна.

3.4 Урсгал зардал, бараа материалын шинж чанартай хөрөнгө оруулалт нэмэгдсэн нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна.

Хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон 247 ТАХ-ний 90,230.0 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгасан байна. Үүнээс Орон нутгийн өмчийн газрын дуусаагүй барилга дансанд 46,917.0 сая төгрөгийн 31 ТАХ бүртгэгджээ.

ТАХ-ний бүртгэлийг эх үүсвэр бүрээр задалбал

Хүснэгт 21

/сая төгрөгөөр/

Эх үүсвэр	Бүртгэсэн	
	ТАХ-ний тоо	Мөнгөн дүн
ОНХО	188	79,066.9
Аймаг БХС	3	2,512.1
АЗСан	3	704.5
ЭТСан	7	472.7
Баян-Өндөр ОНХО	8	1,646.4
Баян-Өндөр БХС	14	594.8
Жаргалант ХО	24	5,232.6
Нийт	247	90,230.0

Дээрх бүртгэгдсэн хөрөнгөөс аймгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ТАХ-ээс 7,174.3 сая төгрөгийн 854 ширхэг тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллага бүртгэсэн бол 1,125.6 сая төгрөгийн 7,322 ширхэг бараа материалыг бүртгэл тайланд тусгагдсан байна.

Төсөл хөтөлбөрийн эх үүсвэрээс аймгийн төсөл хөтөлбөрөөс 11,802.1 сая төгрөгийн 184 ТАХ, БХС-аас 857.5 сая төгрөгийн 17 ТАХ, ЭТСангаас 29.7 сая төгрөгийн 2 ТАХ, АЗСангаас 1,046.8 сая төгрөгийн 3 ТАХ-г нийт 13,736.1 сая төгрөгийн 206 ТАХ-г зардлаар тайлагнасан байна.

Баян-Өндөр сумын хөрөнгө оруулалтаар хийгдсэн ТАХ-ээс 1,880.4 сая төгрөгийн 9 ТАХ-г үндсэн хөрөнгөд, 636.5 сая төгрөгийн 12 ТАХ-г бараа материалд, 2,101.1 сая төгрөгийн 32 ТАХ-нь урсгал зардлаар тайлагнасан байна.

Жаргалант сумын хөрөнгө оруулалтаар хийгдсэн ТАХ-ээс 4,408.3 сая төгрөгийг үндсэн хөрөнгөд, 1,088.7 сая төгрөгийн 24 ТАХ-г бараа материалд, 161.6 сая төгрөгийн 1 ТАХ-г зардлаар тайлагнажээ.

Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд урсгал зардлын шинж чанартай, хөрөнгийн шинж чанаргүй тухайн байгууллагын урсгал төсвөөс шийдвэрлэх

боломжтой бараа материалыг төлөвлөж буй нь Төсвийн тухай хуулийн 4.1.24²⁵-т заасныг зөрчсөн байна.


Хөрөнгө оруулалтын ТАХ-ээс бүртгэл тайланд тусгагдсан боловч хэрэгцээ шаардлагагүй, ашиглалтгүй, үр өгөөжгүй 1,706.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 1,603.3 сая төгрөгийн гэрээний дүнтэй 15 ТАХ байна. Тухайлбал:

Зураг 4 Хэрэгцээ шаардлагагүй ТАХ



БОАЖГ-ын контор, орон сууцны инженерийн шугам сүлжээний 212.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил:

БОАЖГ-ын контор байхаар анх төлөвлөгдсөн боловч 63 айлын орон сууцны зориулалттай болж, БОГ-ны цөөн алба хаагчдыг хөнгөлөлттэй нөхцөлөөр оруулан, хувийн аж ахуйн нэгжийг дэмжсэн, орон нутагт бүртгэх боломжгүй ТАХ, санхүүжүүлсэн.




Хөв цөөрмийн ажлыг дуусгах /Эрдэнэ баг. Бүрэн бүстийн овооны хажууд/ 284.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй ажил:

2023 оноос хойш Ээлт Өлгий ХХК гүйцэтгэж одоог хүртэл дуусаагүй, ач холбогдолгүй, үр өгөөжгүй ТАХ болсон.



Эрчим хүчний хэмнэлттэй Хайбрид амины орон сууц барих 54.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил: ХАА-г зохион байгуулаагүй, дулааны алдагдалгүй байшинг иргэнд барьж өгсөн, орон нутагт бүртгэх боломжгүй, эдийн засгийн ач холбогдолгүй ажил болсон.



Нутгийн удирдлагын ордны 3 дугаар давхрын өрөөг хүндэтгэлийн танхим болгон засварлаж тохижуулах 186.9 сая төгрөгийн 183.2 сая төгрөгийн гэрээний дүнтэй ТАХ нь үр өгөөж тодорхойгүй, ач холбогдолгүй ТАХ байна.



Биеийн тамир спортын газарт тоног төхөөрөмж худалдан авах 120.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 115.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй фитнес тоног төхөөрөмж нийлүүлэх ТАХ нь:

Хэрэгцээ шаардлагагүй хөрөнгө бэлтгэж, хувь иргэнд үнэ төлбөргүй ашиглуулж, төсвийн үр ашиггүй хөрөнгө оруулалт болсон байна.



Чөлөөт бөхийн холбоонд дэвжээ худалдан авах 40.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 39.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй ТАХ нь:

Хэрэгцээ шаардлагыг бодитой тооцоогүй, одоо ашиглаж буй дэвжээ нь шаардлага хангахуйц байтал шинээр дэвжээ худалдан авч үрэлгэн зардал гаргасан байна.



Аялгуу соёлын төвд тоног төхөөрөмж худалдан авах 27.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 26.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй ТАХ нь:

18.4 сая төгрөгийн фитнесс тоног төхөөрөмж нь усанд орох өрөөгүйгээс шалтгаалж ашиглалтгүй хөрөнгө болсон байна.



Шинээр ашиглалтад орох "Номын өргөө"-нд тоног төхөөрөмж худалдан авах 292.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 291.7 сая төгрөгийн гэрээний дүнтэй ТАХ-ээс 4.6 сая төгрөгийн фитнес төхөөрөмж ашиглалтгүй, хэрэгцээ шаардлагагүй хөрөнгө бэлтгэсэн байна.



Уурхайчин баг. Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж худалдан авах 80.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 78.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй тоног төхөөрөмж нь хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлоогүйгээс ашиглалтгүй хөрөнгө бэлтгэсэн байна.



Цэцэрлэгт хүрээлэнд техник хэрэгсэл худалдан авах 19.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж хэрэгцээ шаардлагагүй хөрөнгө бэлтгэснээс болж одоог хүртэл ашиглалтгүй хадгалсаар байна.



Дотоодын цэргийн 816 дугаар ангид тоног төхөөрөмж худалдан авах 70.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 69.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй ТАХ-ээс фитнессын тоног төхөөрөмж ашиглалтгүй, хэрэгцээ шаардлагагүй хөрөнгө оруулалт байна.



Хүндэт харуулын үйл ажиллагаанд шаардлагатай хивс худалдан авах 21.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 21.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй 11 ширхэг хивс нь хэрэгцээ шаардлагагүй, хадгалсаар байна.



Эрдэнэт хотын цахим түүх бүтээх 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 149.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй ТАХ нь эдийн засгийн ач холбогдолгүй, хэрэгцээ шаардлагагүй, бэлэг дурсгалын шинж чанартай хөрөнгө оруулалт болсон байна.



Замын арчилгааны тоног төхөөрөмж худалдан авах / асфальт зүсэгч, цагаан зураас будагч, трамбок / 46.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 46.3 сая төгрөгийн гэрээний дүнтэй 5 ширхэг тоног төхөөрөмжөөс 23.7 сая төгрөгийн өртөгтэй Хэвтээ тэмдэглэгээний машиныг ажиллуулах боловсон хүчин бэлтгээдээгүйн улмаас ашиглалтгүй байна.



Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж худалдан авах 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 94.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй ТАХ нь эдийн засгийн үр өгөөж тодорхойгүй, ач холбогдолгүй хөрөнгө төлөвлөж, ашиглалтгүй хадгалсаар байна.

Дүгнэлт:

- Хөрөнгө оруулалтын ТАХ нь “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой 92.8 хувь нийцэж байгаа ч урсгал зардлын шинж чанартай төсөл хөтөлбөрийн зардал өмнөх оноос өссөн байна.
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг эрэмбэлэн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцоололгүй төлөвлөсөөр байна.
- Эдийн засгийн үр өгөөж бага, хөрөнгө оруулалтын шинж чанаргүй ТАХ-г төлөвлөсөөр байна.
- Тайлант онд өвс тэжээлийн нөөц, давс бодисын нөөцийг ихээр бэлтгэж бараа материалын үлдэгдлийг өмнөх оноос 2 дахин илүү нөөцөлсөн нь Төрийн хэмнэлтийн хуультай нийцэхгүй байна.
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, цахим системд мэдээлсэн байна.
- Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын баталсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнээс 12 ТАХ-г ХАА-ны төлөвлөгөөнд тусгаагүй байна.
- Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал 5 ТАХ-г 11 ТАХ болгон хуваан баталж, үнэлгээний хороо чанарын баталгаа алдангийг харилцан адилгүй шаардаж байна.
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлийн санхүүжилтэд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зураг төсөвгүй, техникийн тодорхойлолтгүй ТАХ баталсан нь хугацаандаа хэрэгжүүлэх боломжийг алдагдуулж байна.
- Техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авсан ч чанарын баталгааг шаардахгүй байгаа нь гэрээний үүргийн биелэлтийг бүрэн хангуулахгүй байх нөхцөлийг бүрдүүлжээ.
- Урсгал зардал, бараа материалын шинж чанартай хөрөнгө оруулалт нэмэгдсэн нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна.

Зөвлөмж:**Аймгийн Засаг даргад:**

- Батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлэх.
- Урсгал зардал, бараа материалын шинж чанартай төсөл арга хэмжээг төлөвлөхгүй байх.
- Бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, хөрөнгө оруулалтын барьцаа дансны үлдэгдлийг төсөл арга хэмжээ тус бүрээр тооцоо нийлж, баталгааны 5%-ийг хөрөнгө оруулалтын барьцаа данснаас олгож байх.

Худалдан авах ажиллагааны газарт:

- Дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлж, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээг авч, зөвлөмжийн хэрэгжилтийг тооцож байх.
- Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ бүрээс чанарын баталгаа, алданги тооцох хувь хэмжээг ижил тэгш шаардаж, гэрээний үүргийн биелэлтийг бүрэн хангуулахад анхаарах.

**“Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний
хэрэгжилтэд, үр дүн” гүйцэтгэлийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Зардлын эх үүсвэр	Төлбөрийн акт	Албан шаардлага
1	“Уртын гол багт баригдаж байгаа 260 айлын 5 блок орон сууцны цогцолборын ажил” төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилтээс захиалагчийн болон зохиогчийн хяналтын зардалд олгогдох 27.8 сая төгрөгийг гүйцэтгэгчээс тухай бүр суутгалгүй дараагийн гүйцэтгэлийн санхүүжилтээс нөхөн суутгасан байна.	ОНХО	-	27.8
2	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 02-ны 17/05 дугаар тогтоолоор “Эрдэнэт сангийн орлогоос 2024 онд санхүүжих хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн зардлын жагсаалт”-д батлагдаагүй төсөл арга хэмжээнд 63.2 сая төгрөгийг зарцуулсан байна.	ЭТСан	-	63.2
3	Номын өргөө бүхий цогцолбор барилга төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилтээс чанарын баталгаа 150.0 сая төгрөгийг 1 жил дуусаагүй байхад гүйцэтгэгчид олгосон байна.	ОНХО	150.0	-
4	“Эрдэнэтэд үйлдвэрлэв” төвийн барилгын зураг төсөл боловсруулах төсөл, арга хэмжээг хүчин төгөлдөр бус баримтад үндэслэн 0.8 сая төгрөгийн алдангийг дутуу суутган, санхүүжилтийг олгосон байна.	Төсөл хөтөлбөр	0.8	-
5	“Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн дотоод хяналтаар Баян-өндөр сум нь тайлант онд 182 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг төлөвлөснөөс төсөв ирүүлээгүй 81, техникийн тодорхойлолт ирүүлээгүй 16, ажлын даалгавар ирүүлээгүй 3 төсөл арга хэмжээ төлөвлөсөн байна.	БӨ сум	-	-
6	“Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотоод хяналтаар Жаргалант сум нь 62 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг төлөвлөснөөс зураг төсөв ирүүлээгүй 9, техникийн тодорхойлолт ирүүлээгүй 3 төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.	Жаргалант сум	-	-
7	“Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийг	ОНХО		

	хэрэгжүүлээгүй, тайлант оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2,007.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 149.4 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 3 төсөл арга хэмжээ нь зураг төсөвгүй, техникийн тодорхойлолтгүй төлөвлөгдсөн байна.		-	-
8	"Хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хамтарсан багийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх" төсөл хөтөлбөрийн хүрээнд "Итгэл дүүрэн гэр" бүл сэтгэл зүйн үйлчилгээ, архинд донтох эмгэгтэй 50 иргэнийг эмчилгээнд хамруулах зорилгоор Оюу сэтгэц наркологийн эмнэлгийн дансанд 6.35 сая төгрөгийг шилжүүлсэн байна.	БӨ сум төсөл хөтөлбөр	6.4	-
9	"Баян-Өндөр уул болон 7 бурхан одны тахилга" хийх арга хэмжээний зардлаас 240,000 төгрөгийн архи, согтууруулах ундаа худалдан авч зарцуулсан байна.	Аймгийн төсөл хөтөлбөр	0.2	-
10	Хувийн хэвшлийн "Бяцхан одод" цэцэрлэгт зуны улиралд чийрэгжүүлэлтийн бүлэг ажиллуулахад анхан шатны баримтын бүрдэлгүй 2,250.0 мянган төгрөг олгосон байна.	Аймгийн төсөл хөтөлбөр	2.3	-
11	Орхон аймгийн Засаг даргын 2024 оны 07 сарын 04-ний өдрийн А/500 дугаар захирамжаар "Эрдэнэтчүүд Эрдэнэтчүүддээ хайртай хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал"-аас "Эрдэнэтэд төгсөгчдийн холбоо" НҮТББ-ын дансанд анхан шатны баримтын бүрдэлгүй 4.2 сая төгрөгийг шилжүүлсэн байна.	Аймгийн төсөл хөтөлбөр	4.2	-
12	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын 45 жилийн ойн хүндэтгэлийн арга хэмжээнд Орхон аймгийн Засаг дарга оролцох үеэрээ "Парис-2024" олимпын тоглолт үзэх сугалаа зохион байгуулж, эрхийн бичиг гардуулсан байна. Орхон аймгийн засаг даргын 2024 оны 07 сарын 26-ны өдрийн А/550 дугаар "Дэмжлэг үзүүлэх тухай" захирамжаар "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Ус хангамжийн цехийн гагнуурчны "Парис-2024" олимп үзэх замын зардал 15.9 сая төгрөгийг төсөл, хөтөлбөрийн зардлаас олгосон байна.	Аймгийн төсөл хөтөлбөр	-	15.9
13	Тайлант онд Булган аймгийн 5 сумын тэгш ой тохиож буйтай холбоотой 100.0 сая төгрөгийн дэмжлэг олгосон байна.	Аймгийн төсөл хөтөлбөр	-	100.0
14	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 09 дүгээр сарын 11-ны өдрийн 18/05 дугаар тогтоолоор хөрөнгө оруулалтын жагсаалтаар баталсан 258.3 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээ нь батлагдсан нэршлээс өөр техникийн тодорхойлолт боловсруулагдаж, нэршилтэй нийцэхгүй тээврийн хэрэгсэл нийлүүлэгдсэн байна.	ОНХО	-	258.3
15	Баян-Өндөр сумын ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны 21/02 дугаар тогтоолоор хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан 345.0 сая	БӨ сум	-	345.0

	төгрөгийн 2 төсөл арга хэмжээ нь батлагдсан нэршлээс өөр техникийн тодорхойлолт боловсруулагдаж, нэршилтэй нийцэхгүй тээврийн хэрэгсэл нийлүүлэгдсэн байна.			
16	Орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн аудитаар өгсөн Гэр бүлийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх, сэтгэлзүйн төв ажиллуулах, сургалт нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах зорилгоор "Эрдэнэт академи" НҮТББ-тай 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 49/23 дугаартай хамтран ажиллах гэрээ байгуулсан боловч гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй, гэрээ дүгнэлгүй 40.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлсэн боловч одоог хүртэл гэрээний үүргийн биелэлт хангагдаагүй, төсөвт 40.0 сая төгрөг төвлөрөөгүй байх тул хуулийн байгууллагад шилжүүлж, төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлт, үр ашиггүй, хяналтгүй зарцуулах нөхцөл бүрдүүлсэн алба хаагч нарт хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.	Аймгийн төсөл хөтөлбөр	-	40.0
	Нийт		163.9	850.2

Байгууллагын санал:



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

Нутгийн удирдлагын ордон, Уртбулаг баг,
Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033
Утас: 7035 5590, Факс: (976) 7035 2621
Цахим шуудан: info@erdenet.mn

2025.05.23 № 01/1776
танай _____ -ны № _____ -т

**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
П.ПҮРЭВЛХАГВА ТАНАА**

Танаас ирүүлсэн 2025 оны 05-р сарын 21-ний өдрийн 221 дүгээр албан бичгээр ирүүлсэн "Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцсан төсөлд тусгах саналгүй болно.

ЗАСАГ ДАРГА



Б.ЗОРИГТБАЯР

6195090779



ОРХОН АЙМАГ
БАЯН-ӨНДӨР СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР


Ш.Отгонбилэгийн гудамж, Оюут Баг,
Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61025
Утас/факс: (976) 70350965
Цахим шуудан: buzdtg@bayanundur.mn,
Цахим хуудас: www.bayanundur.mn

2025. 05. 23 № 03/904

танай _____ -ны № _____ -т

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд "Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" гүйцэтгэлийн аудитын тайлантай холбоотой саналгүй болно.

ДАРГА  Ш.ӨЛЗИЙБАЯР

61 5110759



ОРХОН АЙМАГ
ЖАРГАЛАНТ СУМЫН
ЗАСАГ ДАРГА

Нутгийн удирдлагын ордон, Жаргалант баг,
Жаргалант сум, Орхон аймаг, 61015

Утас: (976) 7039 7214

Цахим шуудан: info@jargalant.mn

Цахим хуудас: https://jargalant.or.gov.mn

2025.05.22 № 01/479

танай _____-ны № _____-т

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Тус сумын орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн гүйцэтгэлийн аудитын тайлантай холбоотой санал байхгүй болно.

ЗАСАГ ДАРГА  Д.УУРАЛ

6125010424

D. Албан бичиг А-5



**ОРХОН АЙМГИЙН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, Эрх чөлөөний өргөн чөлөө-2
Уртбулаг баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033

Утас: (976) 7035 2511

Цахим шуудан: info@or.spa.gov.mn

Цахим хуудас: http://khaag.erdenet.mn

2025.05.23 № 345

танай _____-ны № _____-т

**ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР П.ПҮРЭВЛХАГВА ТАНАА**

Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын тайлантай танилцлаа.

Санал байхгүй болно.

ДАРГА  Д.ОЮУНБАЯР

Борлуулсан

D:\My documents\A-5 doc
6125050165